

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	3
ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	3
2.1. ДХТХМ-ийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн таамаглал, төлөв байдлын шинжилгээний тайлан	3
2.2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж	4
2.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж	5
2.4. Засгийн газраас өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлд өгсөн санал, зөвлөмж	6
2.5. ТТБЗ-ийг институтийн хувьд бэхжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр боловсруулсан санал.....	10
2.6. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж	10
2.7. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд өгсөн дүгнэлт.....	11
2.8. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд өгсөн дүгнэлт	12
2.9. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн дүгнэлт	14
2.10. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, ЭМДС-ийн 2025 оны төсвийн тухай, НДС-ийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн дүгнэлт.....	15
2.11. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн дүгнэлт.....	16
ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА	16
3.1. УИХ, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллага, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцсан байдал	16
3.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцсан байдал.....	18
ДӨРӨВ. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ	19
ТАВ. ЗӨВЛӨЛИЙН ДОТООД АЖИЛ	23
ЗУРГАА. ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ	24
ДОЛОО. БУСАД АЖИЛ	27
НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ЗОРИЛТ	28
Хавсралт 1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал	30
Хавсралт 2. Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд оруулсан өөрчлөлт.....	31
Хавсралт 3. Монгол Улсын төсвийн 1990-2024 оны төлөв байдал	32
Хавсралт 4. Төсөв ба макро хувьсагчдын 2024 оны төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү.....	42
Хавсралт 5. Уул уурхайн секторын 2024 оны төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү	42
Хавсралт 4. Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал	43

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл байнгын ажиллагаатай болсон нь

Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл (ТТБЗ)-ийн орон тооны 7 гишүүнийг УИХ-ын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор томилон ТТБЗ-ийг байнгын үйл ажиллагаатай ажиллуулахаар байгуулсан билээ. Тус Зөвлөл 2024 эхний хагас жилд УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэд, харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн хагас жилд УИХ-ын дэргэд ажиллав.

1.2. ТТБЗ-ийн чиг үүрэг

Төсвийн тухай хууль (ТТХ) болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТТБТХ)-д заасны дагуу ТТБЗ нь “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)-ийн төсөл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг гаргаж, хуульд заасан холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, мөн УИХ-д Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх талаар болон улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн чиг үүрэгтэй.

1.3. Тайлангийн зорилго

Энэхүү тайланг ТТБЗ Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлууд, тэдгээрийн үр дүнг нэгтгэн гаргах зорилгоор боловсруулан УИХ-д хүргүүлж байна.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлангийн энэ хэсэгт ТТБЗ хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, Зөвлөлийн дүрэм, 2024 оны ажлын төлөвлөгөөний дагуу дараах төсвийн баримт бичгүүд, хуулийн төслүүдэд дүгнэлт, зөвлөмж өгсөн талаар тусгалаа.

2.1. ДХТХМ-ийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн таамаглал, төлөв байдлын шинжилгээний тайлан

Монгол Улсын 2025-2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглал, төлөв байдлын шинжилгээний тайланг бэлтгэж, нэгтгэн гаргах ажлыг Зөвлөлийн гишүүд хамтран гүйцэтгэж, ТТБЗ-ийн хурлаар хэлэлцэж эцэслэн боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хуулийн хугацаанд буюу 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлж, тус тайланг УИХ-ын цахим хуудсанд нийтэлсэн болно (<https://www.parliament.mn/nn/62424/>).

Энэхүү тайланг бэлтгэхдээ:

- ДХТХМ боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцооллыг хийж, макро эдийн засгийн загварт суурилан төсөөлөл боловсруулахын тулд ОУВС, Дэлхийн Банк, АХБ-ны суурин төлөөлөгчид, Монголбанк, ЭЗХЯ зэрэг чиг үүрэг ойролцоо байгууллагын холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй Зөвлөлийн дарга, гишүүд уулзаж, харилцан танилцуулга хийж, санал солилцон төсвийн хүрээний

мэдэгдэл боловсруулахад ашиглах макро үзүүлэлтүүдийн таамаг боловсруулах талаар ярилцаж, хамтын ажиллагааны чиглэлээ тогтсон.

- Өөрсдөд тохирох загварыг сонгон авч тухайн загварыг Монголын өгөгдөл дээр ажиллуулах шаардлагатай суурь судалгааг хийж, тус ажилд туслан гүйцэтгэх эксперттэй холбоо тогтоон МУИС дээр ТТБЗ-ийн загвар боловсруулах баг, зөвлөлийн гишүүдийн хамтарсан семинарыг 11 удаа хийсэн. Эдгээр семинарын явцад ОУВС-аас төсвийн төсөөлөл боловсруулахад ашигладаг DIGNAR (2008) загвар, макро-төсвийн бодлогын төсөөлөл боловсруулахад чиглэсэн Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн (NRGI)-ээс 2017 онд бэлтгэсэн загваруудын бүтэц бүрэлдэхүүн, онцлог, мөн чанарын талаар ярилцаж, ТТБЗ-ийн зүгээс загвар боловсруулах ажлыг хариуцсан багийн гишүүдийн бэлтгэсэн илтгэлүүдийг хэлэлцэж байв.
- ТТБЗ болон Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас боловсруулж буй макро эдийн засгийн загварын талаарх хамтарсан уулзалтыг 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордны Үндсэн хууль танхимд хийж ТТБЗ, Монголбанк, ЭЗХЯ-ны төлөөлөл боловсруулж, ашиглаж буй загваруудын талаар танилцуулга хийж, харилцан туршлага солилцож, холбогдох зөвлөмжийг өгсөн.
- Макро эдийн засгийн DIGNAR-19 загвар, Байгалийн нөөцийн Засаглалын хүрээлэнгийн NRGI загварыг Монгол Улсад тохируулан “DIGNAR-M”, “NRGI-FSC 2024” загвар болгон ашиглаж тооцооллыг хоёр хувилбараар гаргасан. Харьцангуй богино цаг хугацаанд тооцоолол хийсэн тул загварт ашиглах тоон мэдээллийг хангалттай хэмжээнд бүрэн цуглуулах боломж хязгаарлагдмал байсныг тэмдэглэх хэрэгтэй.
- Өнгөрсөн жилүүдэд төрөөс эдийн засаг, гадаад худалдааны өндөр зорилтууд тавьж ирсэн ч бодит байдал дээр урьдчилан таамаглах боломжгүй, биднээс үл хамаарах цар тахал, геополитикийн огцом өөрчлөлт, ОХУ-ын эсрэг тогтоосон эдийн засгийн хориг арга хэмжээ, хилийн боомтууд дээр үүсэж байсан саатал, өвөлжилтийн хүндрэл, ган зуд зэрэг олон эрсдэлт хүчин зүйлийн улмаас тэдгээр зорилтод хүрэх боломжгүйд хүрч байсан. Иймээс дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахдаа бусад улс орны туршлага, жишгээр өөдрөг ба суурь хувилбараар гаргаж, Монгол Улсын ДХТХМ-ийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2024-2027 оны таамаглал, төсөөллийг боловсруулж, хуулийн хугацаанд нь УИХ-ын ТБХ, ЭЗХЯ, Сангийн яаманд хүргүүлсэн юм. ТТБЗ-өөс боловсруулсан “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалын дээд, доод хязгаар”-ыг хавсаргав (Хавсралт 1).

2.2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн төсөл”-д ТТБЗ-өөс өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр хүргүүлэв (<https://www.parliament.mn/nn/62424/>).

Зөвлөл уг төсөл нь ТТБЗ-өөс 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр ЭЗХЯ, СЯ-нд хүргүүлсэн “ДХТХМ-ийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тайлан”-д тусгагдсан эдийн засгийн таамаглал, эдийн засгийн гадаад, дотоод эрсдэл, төсвийн зарим үзүүлэлттэй **нийцтэй бус байна** гэж үзсэн.

Зөвлөл дүгнэлт, зөвлөмждөө:

- Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд **төсвийн орлого, зарлагыг ихээхэн хэмжээгээр нэмэгдэхээр тооцсон нь Монгол Улсад мөчлөг дагасан төсвийн бодлого хэвээр хадгалагдахаар** байна. Ийнхүү төсвийн тэлэлтийг цаашид

хэвээр хадгалбал эдийн засгийн хөгжлийг дэмжих, төсвийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах **бодлогын зорилт хэрэгжихгүй байх магадлал өндөр** болно. Түүнчлэн өргөн барьсан ДХТХМ-ийн үзэл баримтлалд энэхүү баримт бичгийн “нийгэм, эдийн засгийн үр дагавар”-ыг зөвхөн “төсөв боловсруулах тооцоолол хийх” хэмээн хэт өнгөц тодорхойлсон гэж үзсэн юм.

- Үүнээс гадна: 1) Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн таамаглал өндөр байгаа нь хэт өөдрөг төсөөлөлд суурилсан, 2) Төсвийн хувьд өмнөх алдаа буюу төсвийн хэт тэлэлт, мөчлөг дагасан, эрсдэлийг нэмэгдүүлэх бодлого хэвээр хадгалагдсан, 3) Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд өмнөх зохисгүй бодлого үргэлжлэх хандлагатай байна.
- Өргөн барьсан төсөлд инфляцыг гурван хувьд хүргэх, өрийн хэмжээ, ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулах, төсвийн алдагдлыг хуулийн хязгаарт барих, улмаар бууруулах, гол үзүүлэлтүүдийг сайжруулах зорилт дэвшүүлсэн нь сайшаалтай боловч эдгээр нь төсөлд тусгагдсан гадаад худалдаа, эдийн засгийн ихээхэн өөдрөг төсөөлөл биелэгдэх үед л хэрэгжих боломжтой гэж үзэж байгаагаа дурдсан.

2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 төсөөлөл нь эдийн засгийн хөгжил, төсвийн тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах шаардлагад нийцсэн байх ёстой гэдэг үүднээс дараах **зөвлөмжийг өгсөн** болно. Үүнд:

- Эдийн засгийн гадаад дотоод эрсдэл, бодит нөхцөл байдлыг ДХТХМ-д харгалзан үзэх, төсвийн орлого нэмэгдэж байгаа үед хуримтлал үүсгэх, эрсдэлийг бууруулах бодлого баримтлах;
- Төсвийн орлогын өөдрөг төсөөлөлд найдаж төсвийг тэлэх бодлогыг үргэлжлүүлэх хандлагаа эргэж харах;
- Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, орлого өндөр байгаа жилүүдэд хуримтлал үүсгэх, мөчлөг сөрсөн бодлого баримтлах шаардлагыг төсөлд харгалзан үзээгүй байгааг анхаарч ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувийг өнөөгийн түвшнээс бууруулж 25-28 хувьд хүргэх;
- Зөвхөн эрдсийн түүхий эдийн экспортод дулдуйдсан бодлого хэрэгжүүлэх нь эдийн засгийн төрөлжилт бий болох нөхцөлийг хязгаарлаж байгаа төдийгүй эдийн засагт учрах эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анхааран үзэх;
- Төсвийн тусгай шаардлагыг хангахаас гадна ТТБТХ-д заасан ДХТХМ-ийн агуулгыг бүрэн тусгаж, хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- Цаашид Засгийн газрын өрийг өнөөгийн үнэ цэнээр бус, нэрлэсэн үнээр тооцох, ДНБ-д харьцуулсан өрийн хэмжээг 40 хувь байхаар ТТБТХ, эсвэл Өрийн удирдлагын тухай хуульд тусгах нь зүйтэй гэсэн зөвлөмж багтсан.

2.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлтэй уялдуулан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

ТТБЗ “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах” тухай УИХ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 16¹.1 дэх заалтад тусгагдсан чиг үүргийн дагуу холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргаж УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд (<https://www.parliament.mn/nn/62468/>) 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн.

ТТБЗ-өөс “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах” тухай УИХ-ын тогтоолын төсөл, түүнд хавсарган өргөн барьсан “Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын

тэргүүлэх чиглэл”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” гэсэн гурван баримт бичигт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хоорондын уялдаа, хамаарал”, “Бодлогын тэргүүлэх чиглэл, жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, үр дүн ба хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт хоорондын уялдаа, нийцэл”, “Хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт, төсөвт үзүүлэх нөлөө”, “2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан дэд бүтцийн зарим төслүүдийн талаар” гэсэн дөрвөн чиглэлээр шинжилгээ хийж, нийт 16 дүгнэлт гаргаж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг УИХ-аар хэлэлцэж, батлахдаа анхаарах чиглэлээр тодорхой зөвлөмжүүдийг санал болгосон юм.

Гэвч УИХ-ын хаврын чуулганаар улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг хэлэлцэж батлаагүй бөгөөд Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 9 дүгээр сард Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан уг төлөвлөгөөг УИХ-д дахин өргөн мэдүүлж, намрын ээлжит чуулганаар хэлэлцэн баталсан. ЭЗХЯ-наас энэхүү төлөвлөгөөнд дүгнэлт авахаар ТТБЗ-д ирүүлээгүй тул Зөвлөл дүгнэлт гаргаагүй болно.

2.4. Засгийн газраас өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлд өгсөн санал, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөлд ТТБЗ-ийн гишүүд Төсвийн тусгай, түүний дотор баялгийн сангуудын талаар урьдчилан хийсэн судалгаандаа тулгуурлан саналаа өгч, Зөвлөлийн хурлаар хэлэлцэн ТТБЗ-өөс уг хуульд өгөх санал, зөвлөмжийг нэгтгэн боловсруулж, УИХ-ын Төсвийн байнгын хороонд 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн болно.

“Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.5-т заасан “үндэсний баялгийг хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах” зарчимтай нийцэж байсан тул хуулийн төслийг ТТБЗ-ийн зүгээс дэмжсэн. Мөн ашигт малтмалын төрөл тус бүрээр тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдүүд нь өөрийн лицензээ төрөл бүрээр бусдад шилжүүлэн олж буй ихээхэн хэмжээний орлогод татвар ногдуулж улсын татварын орлогыг нэмэгдүүлэх, өв залгамжлалаар дамжуулж газрын хэвлийн баялаг удам дамжиж үнэ төлбөргүйгээр шилжих явдлыг хаах сайн үр дагавартай гэж үзсэн юм.

Баялгийн сангуудыг улс төрөөс шууд хамааралтайгаар удирдан зохион байгуулбал ямар муу дагаварт хүрдэг гэдгийг олон улсын туршлага илтгэн харуулдаг тул Үндэсний баялгийн сангийн хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоомжийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дараах санал, зөвлөмжийг хүргүүлсэн. Тухайлбал:

1. Үндэсний Баялгийн Сангийн тухай хуулийг дагалдуулан өргөн барьсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дахин сайтар нягтлан үзэж, орхигдсон заалтуудыг тусгах, хуулийн зүйл, заалтын давхардал, хийдлийг бүрэн арилгах шаардлагатай байна. Тухайлбал: Төсвийн тухай хуулийн 8.4, 8.6, 8.8, 8.9, 12.1.2, 19.1.6, 32.1 заалтад орсон “Ирээдүйн өв сан” гэснийг “Баялгийн сан” гэж өөрчлөх.
2. Улсын төсвийн орлогыг хэлбэлзэл, эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий **Тогтворжуулалтын санд тогтвортой орлого** бүрдэж байх нь нэн чухал бөгөөд экспортын орлого, АМНАТ буурсан нөхцөлд Засгийн газар, Сангийн яам АМНАТ-ийн орлогыг улсын төсвийн орлогод түлхүү хуваарилах сонирхолтой байх боломжтой. Иймээс АМНАТ-ийн орлогыг хуваарилах аргачлалыг нэн тодорхой болгох, төсвийн орлогын төсөөллийг боловсруулах явцад ашиглах гол нэрийн эрдэс баялгийн үнийн төсөөллийг Засгийн газар, Сангийн яамнаас аль болох хараат бус субъект тодорхойлж байх нь төсвийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал.

3. “Үндэсний баялгийн сангийн тухай” хуулийн төслийн 4.1.3-т “Төрөлжсөн сангийн шууд удирдлага гэж төрөлжсөн сантай холбоотой УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, төрөлжсөн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах төрийн захиргааны төв байгууллагыг хэлнэ” гэсэн нь Ирээдүйн өв сангийн шууд удирдлагыг Сангийн яам, Хуримтлалын сангийн удирдлагыг Хөдөлмөр Нийгмийн хамгааллын Яам, Хөгжлийн сангийн удирдлагыг Эдийн Засгийн Хөгжлийн Яам хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Гэтэл энэ нь сангийн удирдлага улс төрөөс ангид байх, сангийн хөрөнгийг захиран зарцуулах механизм нарийн хяналттай, өндөр түвшний зохицуулалттай байх олон улсын нийтлэг зарчимд нийцэхгүй байна. Иймд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудыг удирдах компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг энэ хуульд тусган оруулах шаардлагатай. Үндэсний баялгийн сангийн бүрдэл хэсэг болох төрөлжсөн 3 санг Сангийн Яам, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын Яам, Эдийн Засгийн Хөгжлийн Яам шууд удирдах байдлаар бус, харин Баялгийн сангийн нэгдсэн удирдлагыг Засгийн Газрын танхимд тодорхой нэг субъект хариуцан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.
4. Монгол Улсын Үндсэн хуульд баялгийн сангийн тухай заалт орсон учраас хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ирээдүйн өв сангийн тухай хуульд энэ сан бол “Монгол Улсын Үндэсний баялгийн сан” гэсэн нэг өгүүлбэр оруулж, энэ хуулиар асуудлыг зохицуулаад явах гарц байж болох юм. Ингэхдээ сангийн удирдлагыг хэрэгжүүлэх корпорац нь улс төрийн нөлөө, популизмаас ангид, бие даасан үйл ажиллагаа явуулах, болж өгвөл олон улсын менежментийн баг ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.
5. Тус хуулийн төслийн 12.1-д “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасан байна. Иймд Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1-д заасан¹ үүргээ хэрэгжүүлэхийн тулд, нөгөө талаар бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагын хувьд тус хуулийн төслийн 6.1.1, 6.1.2, 6.1.3 дахь заалтад тусгагдсан Баялгийн сангийн хөрөнгийн жилийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтад тус бүрд нь санал, дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн төрөлжсөн сангуудын хөрөнгө зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийн үнэлгээ өгч түүний үр дүнг УИХ-д болон хэвлэл, мэдээлэл, олон нийтэд нээлттэй мэдээлэхээр оруулах нь зүйтэй гэсэн саналыг гаргасан. Үүний тулд:
- Хуулийн төслийн 7 дугаар зүйл буюу Засгийн газрын бүрэн эрх гэсний өмнө “... дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэн эрх” гэж шинэ зүйл оруулж, “ ... 1. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1.1. Баялгийн сангийн төсвийн тухай хуулийн төсөлд санал, дүгнэлт гарган УИХ-д хүргүүлэн хэвлэл, мэдээлэл, олон нийтэд мэдээлнэ” гэж оруулах.
 - Мөн хуулийн төслийн 14 дүгээр зүйлд “14.4. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь төрөлжсөн сангийн хөрөнгийн зарцуулалтын байдалд судалгаа, шинжилгээ хийж олон нийтэд мэдээлнэ” гэж шинэ заалт оруулах.
6. Үүнээс гадна “Үндэсний баялгийн сан”-г төрөлжсөн 3 сангаас бүрдэх “тогтолцоо” гэж тодорхойлоод орхих бус, Монгол улсын эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах

¹ 16¹.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах болон төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах үүрэг.

зорилгоор газрын хэвлийн баялаг, ашигт малтмалын экспортын орлого, татвар, төсвийн илүүдэл, Монгол банкны нөөц, өмч хувьчлалын орлогоос хөрөнгөө бүрдүүлдэг бие даасан, хараат бус, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шатны зорилт болох “санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх” зорилго бүхий баялгийн сан болгохуйц зохицуулалтыг хуульд тодорхой тусгах шаардлагатай.

7. Дэлхийд тогтворжуулалтын, хөрөнгө оруулалтын, хадгаламжийн, хөгжлийн, тэтгэврийн нөөц сан гэсэн 5 төрлийн баялгийн сан байдаг. Эдгээр сангийн зорилгыг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд тусгагдсан “Ирээдүйн өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан” гэсэн төрөлжсөн сан тус бүрийн зориулалттай харьцуулж үзэхэд: Ирээдүйн өв сан нь **хадгаламжийн** болон **хөрөнгө оруулалтын** сангийн зорилгод нийцсэн байдлаар ажиллахаар байна. Хуримтлалын сангийн тухайд олон улсад хэрэгжиж буй нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэдэг **хөгжлийн сан**, мөн **тэтгэврийн нөөц сан**гийн агуулгатай байгаа боловч Нийгмийн даатгалын тухай хуульд заасан тэтгэврийн сангийн хуримтлалын талаар хуулийн төсөлд огт тусгагдаагүй. Хөгжлийн сан нь улс орны хөгжлийг хангахад чиглэсэн мега төслүүдэд **дэмжлэг үзүүлэх** зориулалттай, харин хөрөнгө оруулалт хийхэд зориулагдах эсэх нь тодорхойгүй байна. Гэтэл байгалийн баялгийн татвар буюу АМНАТ-ийн тодорхой хувиар орлого нь бүрддэг “Тогтворжуулалтын сан”-ийн талаар энэ хуулийн төсөлд огт тусгаагүй байна. Иймээс Үндэсний баялгийн санд хамаарах төрөлжсөн 3 сангийн зориулалтыг нягталж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээр дурдсан нэршлийг ашиглан сан тус бүрийн зорилго, орлого, зарлага, хөрөнгө оруулалтын чиглэлийг илүү тодорхой болгон хуульчлах нь уг хуулийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэхэд нөлөөлнө.
8. Хуулийн төслийн 5.1 дэх заалтад Баялгийн сангийн үйл ажиллагаанд баримтлах 7 зарчмыг тодорхойлсон ч эдгээр нь “тунхаглалын шинжтэй” байгаа бөгөөд эдгээр зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалт хуулийн төсөлд бүрэн тусгагдаагүй байна. Тухайлбал, 5.1.4-т “Баялгийн сангийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчим, сайн засаглал, үнэт зүйлийг үйл ажиллагаандаа баримтлах” гэж тусгасан ч төрөлжсөн сангуудын нэр, зориулалт, эх үүсвэр, зориулалт нь олон улсын нийтлэг жишигт нийцэхээргүй байна. Иймээс баримтлах зарчим тус бүр нь уг хуулийн бүлэг, зүйл, заалт бүрд тусгалаа олсон байхад онцгой анхаарал хандуулах нь чухал юм.

Засгийн газраас боловсруулан 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөлд Зөвлөлөөс санал, дүгнэлт боловсруулж, ТТБЗ-ийн албан тоотоор УИХ-ын Төсвийн байнгын хороонд 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Энэхүү хуулийн төслийг УИХ-ын даргын 2024 оны 52 тоот захирамжаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, хуулийн төслийн танилцуулгад “... хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа болон үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх шаардлагагүй болно” гэж тусгасан байв.

Харин хуулийн төслийн 6 дугаар зүйл буюу “Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх”-д мал аж ахуйн салбарыг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- *6.1.9. Жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх.*
- *6.2. Энэ хуулийн 6.1.9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө гэжээ.*

Эдгээр заалт нь Төсвийн тухай хуулийн дараах заалтуудтай зөрчилдөж байна гэж ТТБЗ үзсэн болно. Тухайлбал:

- 5.1.3. санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх
- 6.2.3. урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх
- 6.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх
- 10.1.2. УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар батлах
- 10.1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
- 34.1. Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
 - 34.1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн
 - 34.1.2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх
 - 34.1.3. Энэ хуулийн 29.7-д² заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах
 - 34.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.

Иймд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд нь бусад салбарын төсөв, санхүүгийн талаарх зохицуулалт бүхий органик шинжтэй хууль болж мөрдөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд тусгайлан ямар нэгэн хууль, тогтоомжид дээрх хуулийн төслийн 6.1.9 болон 6.2-д заасан шиг заалтууд орж батлагдах нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг ноцтой зөрчих, цаашид бусад салбар өөр өөрсдийн хууль, тогтоомжид салбарын төсөв, санхүүгийн зохицуулалттай холбоотой заалтыг шинээр бий болгох, ингэснээр төсвийн үндсэн зарчмуудыг мөрдөхгүй байх сөрөг үр дагавар үүсэх магадлал бий болно.

Цаашид төсөв, санхүүгийн эрх зүйн зохицуулалтыг улам сайжруулах, бусад улс оронд хэрэглэж буй эрх зүйн зохицуулалтыг судалсны үндсэн дээр Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах замаар шийдвэрлэх саналтай байна. Тухайлбал, “Хэрэв Засгийн газар УИХ-аар хуульчлан баталсан жилийн төсөвт өөрчлөлт хийх шаардлагатай бол энэ тухайгаа УИХ-д болон Төсвийн байнгын хороонд холбогдох үндэслэл, тайлбарыг гаргаж, тэрхүү үндэслэл, тайлбарт Төсвийн байнгын хороо болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үнэлгээ хийж, үндэслэлтэй гэж үзэн зөвшөөрөл өгсөн тохиолдолд төсөвт тодотгол хийхгүйгээр Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийж болно” гэсэн заалтыг оруулж шийдвэрлэхийг санал болгосон юм.

² Төсвийн тухай хуулийн 29.7-г “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө” гэж заасан.

2.5. ТТБЗ-ийг институцийн хувьд бэхжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр боловсруулсан санал

“ТТБЗ-ийн статус, институцийн бие даасан байдлыг хуульчлах” асуудлыг хариуцсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, ТТБТХ-д болон ТТБЗ-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийн саналыг бэлтгэж, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, нэгдсэн шийдвэрт хүрч ТБХ-ны дарга Г.Тэмүүлэнтэй 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдөр ТТБЗ-ийн дарга, гишүүд уулзаж, ТТБЗ-ийн ажлын явц болон ТТБТХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналын талаар танилцуулж, харилцан санал солилцсон. ТТБЗ-ийн үйл ажиллагааны дүрмийн төслийг Зөвлөлийн өмнө нь батлагдсан дүрэм, Зөвлөлөөс боловсруулсан ТТБТХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал, 2018 онд ТБХ-оор батлагдсан Зөвлөлийн үйл ажиллагааны журамд үндэслэн боловсруулсан болно.

ТТБТХ-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал, ТТБЗ-ийн үйл ажиллагааны дүрмийн төслийг Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 1-ний хурлаар заалт нэг бүрээр хэлэлцэж, ТБХ, хуулийн зөвлөхөд хүргүүлсэн. Уг хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар баталсан <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140843014111&showType=1>.

2.6. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж

Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын ээлжит бус чуулганд өргөн барьсан юм.

ТТБЗ эдгээр хуулийн төсөлтэй танилцаад хэрэв хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд өмнө тусгагдсан эдгээр төслийг дахин тодотгох, тооцоолол, хөрөнгийн эх үүсвэрийг нь шинэчлэх шаардлагатай гэж үзвэл төсвийн тодотгол хийхийн өмнө дээр дурдсан Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шинэчлэн батлах нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцнэ гэсэн байр суурьтай байв.

Тийм учраас, Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт тодотгол хийхээс илүүтэй ирэх 2025 оны төсвийн төсөлд эдгээр төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусган хэлэлцэх нь илүү зохистой гэж үзэн дүгнэлтээ боловсруулж, УИХ-д 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн юм <https://www.parliament.mn/nn/62776/>.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлтийн тухайд: Хуульд оруулах эдгээр нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсыг төсвийн эрсдэлээс хамгаалах гол хэрэгсэл болох төсвийн тусгай шаардлагуудыг хөнджээ. Тус зөвлөл нь төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүрэг хүлээсэн байгууллагын хувьд эдгээр заалтын нэгээс бусдыг нь төсвийн үзэл баримтлалд нийцэхгүйн дээр төсвийн эрсдэлийг эрс нэмэгдүүлэх хандлагатай хэмээн үзсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд: Хөгжлийн төлөө гэх нэрийн дор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон өмнө батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх нь дараах сөрөг нөлөөллийг бий болгох эрсдэл дагуулж байна гэж дүгнэсэн. Үүнд:

- Макро эдийн засгийн бодлогын хувьд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг өсгөж, төрийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэхээр байгаа нь хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн суурийг тэлэх боломжийг хязгаарлаж байна.

- Төсвийн гол үзүүлэлтүүд болох орлого, зарлага, алдагдлыг хэт өсгөн төлөвлөх боломжийг бүрдүүлсэн байна.

Эндээс, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудад өөрчлөлт оруулах байдлаар төсвийн бодлогын гол баримт болох Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх нь төсвийн бодлого, эрх зүйн зохицуулалт, тогтвортой байдлын хувьд нийцтэй бус гэж үзсэн. Учир нь, энэ нь төсвийн бодлогын хувьд хэт тэлэлтийг дэмжсэн, төсвийн тусгай шаардлагын хэрэгжилтийг сулруулсан өөрчлөлт болох юм.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд орж буй гол өөрчлөлт нь бодлого, үзэл баримтлал, хуулийн өөрчлөлт, Төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд авч үзвэл төсвийн зарлагыг нэмэгдүүлэх, ялангуяа хөрөнгийн зардлыг өсгөхөд чиглэсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгагдсан хөгжлийн хөрөнгө оруулалтын тухайд: Төсвийн тодотголын танилцуулгад тусгаснаар хөгжлийн хөрөнгө оруулалтад хамаарах улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн 442.6 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжаар хэрэгжих хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийн Монголын талаас гаргах санхүүжилтийн дүн 911.4 тэрбум төгрөг тус тус байна. Эдгээр хөрөнгө оруулалтын нийт дүн 1,354.0 тэрбум төгрөг болж байгаа бол зөрүү 443.7 тэрбум төгрөг юунд зарцуулагдах, нэмэгдэж буй нийт хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн 2024 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өнөөгийн байдлаар 24.6 хувьтай (<https://publicinvestment.gov.mn/>) буюу хангалтгүй хэрэгжиж байгаа нь шинээр тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүд хугацаандаа хэрэгжих магадлал багатайг илтгэнэ.

Дүгнэлт: Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор тодорхой төсвийн тодотголыг хязгаарлагдмал хүрээнд хийж болох боловч өргөн барьсан төсөл нь төсвийн дунд хугацааны бодлогын баримт бичиг, төсвийн тогтвортой байдлын эрх зүйн орчин, төсвийн бодлогын томоохон өөрчлөлтийг агуулсан байна. Иймээс: а) Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу өмнө баталсан хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэх шаардлагатай, б) Төсвийн тогтвортой байдлын гол үндэс болсон төсвийн тусгай шаардлагын агуулга, хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах магадлалтай, в) Төсвийн тэлэлт, алдагдал нэмэгдэх боломжийг нээж төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй гэж үзэж байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад төсвийн тогтвортой байдал амин чухал зүйл бөгөөд Засгийн газраас боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын гаргасан төсвийн төлөвлөлтийг боловсруулах аргачлал болон дэлхийн бусад орны шинэчлэлийн чиг хандлагаас өөрөөр, суурь судалгаагүй боловсруулсан байна. Иймд Төсвийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэхийн өмнө эрх зүйн орчин болон макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдалд үүсэх эерэг, сөрөг үр дагаврын талаар үндэслэлтэй суурь судалгааг хийх нь зүйтэй гээд нийт 8 тодорхой зөвлөмжийг өгсөн болно.

2.7. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд өгсөн дүгнэлт

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “16¹.5.3. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”, “7.1.3. Төсвийн тусгай шаардлагыг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлах үйл

ажиллагаанд баримтална” гэсэн заалтуудыг үндэслэн дүгнэлт гаргаж, УИХ-д 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлэв (<https://www.parliament.mn/nn/62893/>).

Зөвлөл дүгнэлт гаргахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасны дагуу тайлагнагдсан эсэхэд анхаарсан болно.

ТТБЗ-өөс Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 9, үндэслэл, нотолгоо бүхий нийт 15 дүгнэлт гаргасан юм.

2.8. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд өгсөн дүгнэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол улсын 2025 оны төсвийн тухай” хуулийн төсөлд дүгнэлт гаргаж, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн (<https://www.parliament.mn/nn/62969/>).

Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-т заасны дагуу боловсруулагдсан эсэхэд анхаарсан болно.

ТТБЗ Монгол Улсад нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн хувьд төсвийн орлогыг эдийн засгийн мөчлөг дагуулан өндрөөр төлөвлөж буйн зэрэгцээ Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого, татварын орлогын өсөлт өндөр байгаа нь бодлогын сонголтыг эргэн харахад хүргэхээс гадна татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хавтгайруулах хандлага ажиглагдаж байна гэж дүгнэсэн.

Харин *төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн тухайд* эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр, төрийн бодлого, төсвийн зарлагын тэргүүлэх чиглэл нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбар, эдийн засгийн үйл ажиллагаа болж байгаа төлийгүй урсгал болон хөрөнгийн зардлын дийлэнх хувийг 7-8 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад зарцуулж байгаа ч төсвийн зарцуулалтын шалгуур үзүүлэлтүүд тодорхойгүй нь зарлагыг оновчтой төлөвлөх шаардлагыг бий боломжгүй болгож байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй гэсэн дүгнэлт, зөвлөмжийг өгсөн юм.

Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь макро эдийн засаг, нийгмийн тэргүүлэх зорилгод чиглэж, нэмэгдэж байгаа нь сайшаалтай ч хөгжлийн хөрөнгө оруулалтыг зөв сонгох, эдийн засгийн үр ашгийг урьдчилан нарийн тооцдог байх шаардлага, хөрөнгө оруулалтын тэлэлттэй холбоотой бий болж байна. Төсөвт тусгагдсан хөгжлийн төслүүд нь гарцаагүй нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүд мөн эсэх, ямар эрэмбэтэйгээр төсвийн төсөлд тусгагдсан нь бүрхэг, тодорхойгүй байна.

Он дамжсан, урт хугацаанд сунжирсан хөрөнгө оруулалтыг багасгах бодлогыг баримталж байгаа нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд эерэг нөлөөлөх боломжтой. Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хуульд заасан хөрөнгө оруулалтын шалгуурыг иж бүрнээр ашиглах, сонгон шалгаруулах үйл явцыг ил тод болгох, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц хууль эрх зүйн орчин хэрэгтэй. Хөрөнгө оруулалтыг төлөвлөхөөс эхлээд сонгон шалгаруулах үйл ажиллагаа ил тод бус, зарим шалгуур хангахгүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтад хамруулж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулах шаардлагыг бий болгож байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлж буй аливаа хуулийн төслийг боловсруулах явцдаа хэд хэдэн судалгаа, үнэлгээг хийсэн байх шаардлагыг тавьдаг. Гэвч энэ хуульд **төсвийн хууль, төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдлийг хамруулахгүй байгаагийн** улмаас эдгээр чухал шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусган өргөн мэдүүлж байгаа нь **хугацаа сунжирсан, өртөг өндөржсөн төслүүд бий болох үүд хаалгыг нээж** байна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцох үйл ажиллагааг журмаар зохицуулах нь хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орны сайн туршлагын дагуу **Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах** асуудлыг УИХ-аас тусгайлан судалж холбогдох шийдвэрийг гаргах шаардлагатай. Түүнчлэн өндөр хөгжилтэй зарим улс орнуудын туршлагаар мэргэжлийн нэг корпорац төсвийн хөрөнгө оруулалтын захиалга, гүйцэтгэлийг дагнан хариуцдаг байх зохицуулалтыг уг хуульд тусгаж өгөх нь зүйтэй. Ингэснээр Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын сайд нар ямар нэгэн барилга барих, тендер шалгаруулах асуудалд хүн хүч, цагаа үрэх бус тухайн салбарынхаа үндсэн бодлогын асуудалд түлхүү анхаарах боломж бүрдэх юм. Үүнээс гадна хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг бодитой тооцох арга зүй, ТЭЗҮ, зураг төслийн зардлын тодорхой стандарт, шалгууртай болж, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн оновчтой хувилбарыг тодорхойлох нь зүйтэй гэсэн дүгнэлт, зөвлөмжийг өгсөн болно.

Засгийн газрын нийт өр, төлбөрийн талаар Засгийн газрын өрийн үлдэгдэл жил ирэх тусам нэмэгдэж байгаагийн зэрэгцээ Засгийн газрын гадаад зээлийн хүүний төлбөр хэт өндөр, нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ашгийг аль болохоор гадаад өрийн үлдэгдлийг бууруулахад ашигладаг байх хэрэгтэй гэж дүгнэсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухайд татаас олгосон ч алдагдалтай ажилласан хэвээр байгаа нь **эрүүл мэндийн заавал даатгалын хувь хэмжээ бага** (дэлхийн улс орнуудад 5-37 хувь байдаг бол манай улсад 4 хувь), **сангийн мөнгийг хэмнэх чиглэлд хөшүүрэг дутмаг, зарцуулах чиглэлд боломж өндөр байгаатай холбоотой** гэсэн дүгнэлтийг өгсөн юм.

Харин **нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухайд** сангийн алдагдал жил бүр нэмэгдэх хандлагатай байгаа тул нийгмийн даатгалын шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Дүгнэвэл, Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь бодлогын хувьд макро эдийн засгийн зорилгод чиглэсэн, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх байдлаараа урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцтэй байна. Харин төсвийн төлөвлөлтийн хувьд цаашид анхаарах шаардлагатай тодорхой хэд хэдэн асуудлууд байна. Үүнд:

Нэгдүгээрт: Өнөөгийн байдлаар дотоод эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа боловч төсвийн орлогын төлөвлөлтөд гадаад орчин, эрсдэлт хүчин зүйлсийг багасгаж тооцсон, харин нөхцөл байдалд хэт өдрөгөөр хандсан, мөчлөг дагасан байдал хэвээр үргэлжлэх, төсвийн орлого, татварын бодлого нь зөвхөн төрийн зардлыг санхүүжүүлэхэд чиглэж байгааг анхаарах нь зүйтэй.

Хоёрдугаарт, Төсвийн зарлага сүүлийн жилүүдэд хэт өсөж эдийн засаг дахь төрийн оролцоо ихээр нэмэгдэж байгаа нь төсвийн болон хөгжлийн бодлоготой нийцтэй бус төдийгүй хувийн хэвшил, мөнгөний бодлогын орон зайг хязгаарлах гол нөхцөл болохоор байна.

Гуравдугаарт, Хөрөнгө оруулалтын бодлого чиглэл, бүтцийн хувьд сайжирч байгаа боловч макро эдийн засаг, нийгмийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь санхүүжилтийн эрсдэл, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болзошгүй юм. Хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх хууль эрх зүйн орчныг эрс сайжруулах шаардлагатай гэж үзсэн. Төсвийн тогтвортой байдлын үүднээс дээрх эрсдэлийг онцгой анхаарч, харгалзан үзэх нь зайлшгүй юм.

2.9. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн дүгнэлт

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг судлан үзээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтыг үндэслэн Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс дүгнэлт гаргаж, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-д хүргүүлэв (<https://www.parliament.mn/nn/62972/>). Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 12.1, 12.3 дугаар зүйлд тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана”, “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга”-д нийцсэн эсэх, Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсөв боловсруулах үзэл баримтлалд нийцтэй эсэхэд анхаарч дүгнэлтээ өгсөн болно.

Уг төсөл нь *Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх талаар* авч үзэхэд нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх шаардлагын дагуу өргөн мэдүүлсэн төсөлд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129 ам.доллар байхаар төсөөлжээ. Гэтэл алт, төмрийн хүдэр зэрэг бусад гол нэрийн бүтээгдэхүүний үнийн төсөөллийн талаар дурдаагүй байна. Үүнээс гадна ТТБЗ нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх нөхцөл бүрдэхгүй байж болзошгүй бөгөөд Засгийн газар төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын өрийн нийт хэмжээнд зөрүү үүсгэсэн, олон нийтийн хэлэлцүүлэг хийхтэй холбоотой холбогдох заалтуудыг мөрдөөгүй, төсвийн хүрээний мэдэгдлийн агуулгад хамаарах үзүүлэлтүүдийг бүрэн тусгаагүй, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн таамаглалтай уялдах хуулийн зарим заалт хэрэгжээгүй гэж дүгнэсэн юм.

Харин *төсөв, макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдсан эсэх болон төсөв боловсруулах үзэл баримтлалд нийцтэй эсэх талаарх* дүгнэлтдээ өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд ДНБ-ий өсөлтийг 2025 онд эдийн засгийн гадаад, дотоод орчны таатай нөхцөл байдалтай уялдуулан хэт өөдрөг тооцсон нь төсвийг тэлэх орон зайг бий болгосон, түүнчлэн эдийн засгийн төрөлжилт муу байгаагаас шалтгаалан дотоод эдийн засгийн идэвхжил буурах мөчлөгт дахин орж, төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг бий болгох буюу төсөв, урсгал тэнцлийн хос алдагдлын мөчлөгт эдийн засгийг оруулж болзошгүй, төсвийн төслийг дагуулан төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхөөр өргөн барьж, төсөвтэй хамт хэлэлцэн батлах буруу жишиг тогтож байгаа, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх томоохон төслүүдийн санхүүжилтийг гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээс илүүтэй Үндэсний баялгийн санд үүсгэсэн хуримтлалаас санхүүжүүлэх нь ирээдүйд урт хугацаанд нэмүү өртөг бий болгох, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж үзсэн болно.

2.10. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, ЭМДС-ийн 2025 оны төсвийн тухай, НДС-ийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн дүгнэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас УИХ-д 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16³.5.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтыг үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр дүгнэлт гаргаж, УИХ-д хүргүүлсэн (<https://www.parliament.mn/nn/63556/>).

Засгийн газар өргөн мэдүүлсэн төсөлд төсвийн орлогыг эдийн засгийн мөчлөг дагуулан өндрөөр төлөвлөсөөр байгаа ч төсвийн орлогыг анх удаа бууруулан тодорхой тооцоолол үндэслэлийг гаргасан, сүүлийн жилүүдэд бий болсон уул уурхайн орлогын огцом өсөлтийг дагаж тэнцвэржүүлсэн орлого, татварын орлого өсөж байгаа нь тогтвортой бус хандлага тул төсвийн орлогын таамаглалыг сайжруулах, эрсдэлийг тооцох нь зайлшгүй, түүнчлэн төсвийн орлогын ангилалд бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай гэж Зөвлөл дүгнэсэн юм.

Төсвийн зарлагын тухайд эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр хэвээр байгаа, урсгал зардлыг бууруулах зорилгоор хийсэн өөрчлөлт нь төсвийн зардлын ангилал, бодлогын хувьд зүйтэй эхлэл болсон, урсгал зардлыг бууруулахдаа цалин, тэтгэврийн суурь түвшин, ирэх жилд олгох нэмэгдлийг хөндөөгүйг бодлогын хувьд хүлээн зөвшөөрөх боломжтой ч төрийн албаны бүтэц, албан хаагчдын тоо, бүтээмжид илүүтэй анхаарах, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг тууштай хэрэгжүүлж, ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрүүдийг төсвийн эдийн засгийн ангилалтай уялдуулж, үр дүнг тооцдог болох шаардлагатай гэж үзсэн болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд өмнө нь өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад санхүүжилтийн хэмжээг багасгасан төдийгүй төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг тодорхой журам, шалгуурын дагуу эрэмбэлж төсөвт тусгах тал дээр тодорхой ахиц гарч байгаа, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиггүй зарцуулахаас сэргийлэх бодлогыг баримталж буйг сайшаасан. Үүнээс гадна хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, удирдлага, төлөвлөлтийн системийг сайжруулах, төсвийн хөрөнгийн ба урсгал зардал хоорондын хамаарлыг тооцож төсвийг төлөвлөдөг байх, хөрөнгө оруулалтыг асуудал хуримтлагдсан тодорхой салбарт илүү ач холбогдол өгч хуваарилах шаардлагатай гэсэн зөвлөмжийг өгч, төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа хэдий ч үр ашигтай эсэх нь эргэлзээтэй байгаа талаар дүгнэлтдээ дурдсан.

Засгийн газрын нийт өр, төлбөрийн талаар дунд хугацааны ТХМ-ийн төсөлд тусгагдсан Засгийн газрын өрийн үлдэгдлийн нийт хэмжээ болон Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн танилцуулгад тусгагдсан дүн зөрүүтэй байсныг илрүүлж, жилийн төсвийн төсөлд Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн дагуу УИХ-аар зээлийн гэрээ нь соёрхон батлагдсан гадаад зээлийн ашиглалтыг л тусгаж байх хэрэгтэй гэж үзсэн юм. *Орон нутгийн төсвийн тухайд* улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн зохицуулалтыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчлэх нь орон нутаг, бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжих, идэвх санаачлагыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой гэж зөвлөсөн.

³ Climate Crossroads: Fiscal Policies in a Warming World. IMF Fiscal Monitor, October 2023 хуудас 76.

² ОУВС-ийн 2024 оны 10-р сарын тайланд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2025 онд 7 хувь байхаар таамагласан.

2.11. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн дүгнэлт

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг судлан үзээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.5.2} дахь заалтыг үндэслэн Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдөр дүгнэлтээ гаргав (<https://www.parliament.mn/nn/63557/>).

Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь *Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэхийн тухайд* нэгдсэн төсвийн орлогыг тооцохдоо 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 129 ам.доллар байхаар төсөөлсөн нь “**төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж байна**” гэж тус зөвлөлөөс өмнө өгч байсан дүгнэлтээ дахин өгөхөд хүргэсэн юм. Хэрэв 2025 онд гадаад, дотоод хүчин зүйлийн улмаас эдийн засгийн идэвхжил суларч, ДНБ-ий өсөлт 8 хувьд хүрэхгүй тохиолдолд тэнцвэржүүлсэн орлого буурах, нэгдсэн төсвийн суурь тэнцэл сөрөг гарах нөхцөл бүрдэхийг анхаарах шаардлагатай.

Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг зөрүүтэй тусгаснаас гадна ДХТХМ-ийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн таамаглалд үндэслэн боловсруулахтай холбоотой Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.6} дахь заалт хэрэгжээгүй хэвээр байна, төсвийн хүрээний мэдэгдлийн агуулгад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3-т заасан нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд бүрэн тусгагдаагүй байна.

Төсөв, макро эдийн засгийн тогтвортой байдал хангагдсан эсэх болон төсөв боловсруулах үзэл баримтлалд нийцтэй эсэхийн тухайд макро эдийн засгийн үзүүлэлтийг өөдрөгөөр төсөөлсөн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 дугаар сард оруулсан нэмэлт өөрчлөлтийг эргэн харах, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тооцоолон оруулж ирсэн нь сайшаалтай ч ирэх онд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ төлөвлөж байснаар биелэгдэхгүй тохиолдолд нийт тэнцвэржүүлсэн алдагдал бий болох магадлалтай. эдийн засгийн мөчлөг дагасан бодлого нь өргөн мэдүүлсэн ТХМ-ийн төсөлд хэвээр хадгалагдаж байгаа тул цаашид эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогын бодитой суурийг тавих шаардлагатай гэж ТТБЗ үзсэн болно.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1. УИХ, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллага, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцсан байдал

1. Үндэсний статистикийн хороо (2024.02.02-ны 15:00 цагт), Монголбанк (2024.02.05-ны 14:30 цагт), Санхүүгийн зохицуулах хороо (2024.02.06-ны 12:00 цагт)-ны дарга, удирдах албан тушаалтнууд, мөн ОУВС (2024.02.06-ны 10:00 цагт), АХБ (2024.02.07-ны 11:30 цагт), Дэлхийн банк (2024.02.07-ны 16:00 цагт), НҮБХХ (2024.03.20-ны 14 цагт), ЖАЙКА (2024.04.03-ны 10 цагт) зэрэг байгууллагуудтай хийсэн албан ёсны уулзалтад ТТБЗ-ийн дарга, гишүүд оролцож, хамтран ажиллах талаар санал, бодлоо хуваалцав.
2. ТТБЗ-өөс ЭЗХЯ, Сангийн яамны удирдах ажилтнуудын төлөөлөлтэй Төрийн ордны Үндсэн хууль танхимд хийсэн (2024.02.15) уулзалтад Зөвлөлийн дарга, гишүүд оролцож, асуулт асууж, хариулт авсны зэрэгцээ макро-төсвийн загвар боловсруулах, загварт ашиглах өгөгдлийг цуглуулах, төсвийн дунд хугацааны зарлагын хүрээний мөн чанарын талаар харилцан ярилцсан.

3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, гишүүн Л.Отгонтуяа нар Удирдлагын академийн захирал доктор, дэд профессор Д.Сүрэнчимэгтэй 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдөр ажил хэргийн уулзалт хийв. Уулзалтаар Удирдлагын академи болон Төсвийн Тогтвортой байдлын зөвлөлийн хамтын ажиллагааны талаар санал солилцсон бөгөөд төрийн бодлогын асуудлаар тинк танкийг бий болгох, төрийн албан хаагчийн сургалт зохион байгуулахад Зөвлөлийн дарга, гишүүдийг оролцуулах, цаашид олон улсын байгууллагаас эдийн засаг, төсөв, санхүүгийн чиглэлээр зохион байгуулдаг сургалтыг Монгол Улсад нутагшуулан, ижил түвшний төрийн албан хаагчдыг хамтран сургах тухай хэлэлцсэн. Мөн салбар, байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдад чиглэсэн сургалт зохион байгуулах боломжийн тухай ярилцсан. Захирал Д.Сүрэнчимэг Удирдлагын академиас эрхлэн гаргадаг “Удирдахуйн онол, практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний бичиг, “Төрийн удирдлага” сэтгүүлийн дугааруудыг ТТБЗ-ийн албан хэрэгцээнд зориулан хүлээлгэн өгсөн юм.
4. ТТБЗ-өөс боловсруулж буй макро-төсвийн загварын талаар танилцуулах ТТБЗ болон ОУВС, Дэлхийн банкны хамтарсан уулзалтыг 2024 оны 3 дугаар сарын 7-ны 14:30 цагт зохион байгуулахад Зөвлөлийн дарга, гишүүд бүрэн оролцож, санал бодлоо солилцсон.
5. ЭЗХЯ-аас 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэгт Зөвлөлийн дарга, гишүүд оролцож, Зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан ТТБЗ-өөс “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл”-д өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулга хийж, хэлэлцүүлэгт панелистаар оролцож, оролцогчдын асуултад хариулт өгөв.
6. ННФ-ын судлаачдын багийн гүйцэтгэсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт” сэдэвт судалгааны үр дүнгийн хэлэлцүүлэг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулагдахад Зөвлөлийн дарга, зарим гишүүд оролцож, өөрсдийн саналыг илэрхийлсэн.
7. Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнтэй 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр уулзалт хийж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс Монгол Улсын төсөв, санхүүгийн ил тод, тогтвортой байдлыг хангахын тулд бие даасан, хараат бусаар ажиллах, мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг Улсын Их Хуралд болон олон нийтэд хүргэх зэрэг үйл ажиллагааны талаар болон 2024 оны төсвийн тодотголд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулсан.
8. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, ЭЗХЯ-ны макро эдийн засгийн бодлогын Л.Энх-Амгалан болон албаны бусад хүмүүс ТТБЗ-ийн ажлын байранд 2024 оны 9 дүгээр 11-ний өдөр ирж, Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн талаар танилцуулга хийж, Зөвлөлийн дарга, гишүүдтэй санал солилцсон.
9. Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат бусад холбогдох албан хаагчидтай 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Сангийн яаман дээр уулзаж, 2025 оны төсвийн төсөл, цаашид хамтран ажиллах талаар харилцан санал ярилцав.
10. УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдэд 2024 оны 10 дугаар 21-ний өдөр “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт”, зөвлөмжийг дэлгэрэнгүй танилцуулж, холбогдох асуудлаар гишүүдийн асуусан асуултад хариулт өгсөн.
11. Барилгын хөгжлийн төвийн Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Давааням “Монгол Улсын хүн амын нутагшил суурьшлын ерөнхий төлөвлөгөө”-ний

талаар 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ТТБЗ-ийн гишүүдэд танилцуулга хийж, харилцан санал солилцсон.

12. УИХ-ын дарга Д.Амарбаясгалан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, УИХ-ын гишүүн Б.Заяабал, Б.Түвшин, Ж.Батжаргал нартай 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр уулзалт хийж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, 2025 оны төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулсан.
13. ЖАЙКА олон улсын байгууллагатай макро эдийн засаг, төсвийн асуудлаар 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр уулзалт хийж, улмаар Зөвлөлийн гишүүд болон зөвлөлийн харьяанд ажиллах төсвийн судалгааны нэгжийн судлаачдын чадавхыг бэхжүүлэх болон зарим тодорхой асуудлаар хамтран ажиллах талаар харилцан санал солилцсон.
14. ТТБЗ-ийн дарга, гишүүд УИХ-ын 2024 оны намрын ээлжит бус болон ээлжит чуулганаар Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл, дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдлийн төслүүдийг хэлэлцэхэд УИХ-ын чуулганы хуралдаан, Төсвийн байнгын хороо, Зарлагын хяналтын дэд хороо болон ажлын хэсгүүдийн хуралд оролцож, ТТБЗ-өөс гаргасан дүгнэлтийг танилцуулж, УИХ-ын гишүүдийн тавьсан асуултад хариулт өгч ажиллав.
15. Япон улсын ЖАЙКА байгууллагаас Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яаман дээр 2025 оноос хэрэгжүүлэх “Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх” төслийн танилцуулах уулзалтад Зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Л.Отгонтуяа, Л.Гангэрэл нар оролцож Монгол Улсын эдийн засаг дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн өнөөгийн байдал, цаашид сайжруулах арга зам, төслийн тогтвортой байдлыг хангах талаар өөрсдийн санал, бодлыг илэрхийлэв.
16. Япон улсаас Монгол Улсад өгөх иений гадаад зээллэгтэй холбоотой ЖАЙКА байгууллагаас ирсэн Монгол Улсын эдийн засгийн үнэлгээний багийнхантай гишүүн Л.Гангэрэл уулзаж манай улсын төсвийн тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэл өгөв.

3.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцсан байдал

- ТБХ-ны дарга болон ТТБЗ-ийн дарга, гишүүд 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Төрийн ордны Үндсэн хууль танхимд хийсэн хэвлэлийн бага хуралд Зөвлөлийн дарга, гишүүд оролцож, сэтгүүлчдийн асуултад хариулсан.
- Зөвлөлөөс зохион байгуулсан “ТТБЗ-ийн үйл ажиллагааг танилцуулах” (2024.03.04-ний 11 цагт), “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тайлан” (2024.03.21-ний 11 цагт), Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн ДХТХМ, Монгол Улсын 2025-2027 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмж (2024.05.14-ний 11 цагт)-ийн талаарх хэвлэлийн бага хурлуудад Зөвлөлийн дарга, гишүүд оролцож, танилцуулга мэдээлэл хийсэн.
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Нээлттэй Нийгэм Форумтай хамтран 2025 оны төсвийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Сангийн яамнаас 2025 оны төсвийн төслийн төлөвлөлтийн талаар, Үндэсний Аудитын газраас төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт, Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс 2025 оны төсвийн төслийн талаар гаргасан дүгнэлтээ тус тус танилцуулсан. Хэлэлцүүлэгт их дээд сургуулийн эрдэмтэн багш судлаачид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцож хэлэлцэж буй асуудлаар олон талын санал, бодол, шүүмжлэлээ илэрхийлсэн.
- Улсын төсвийг боловсруулах явцад төсвийн хөрөнгө оруулалтад анхаарах зүйлс болон 2025 оны улсын төсвийн талаар Зөвлөлийн дарга Н.Энхбаяр, гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан нар ТТБЗ-ийн гишүүний хувиар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэд хэдэн

удаа ярилцлага өгч ажилласан. Монгол Улсад дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ТТБЗ-ийн үйл ажиллагаа, дундаж давхаргыг тэлэх, малчдад учирч буй эрсдэлээс сэргийлэх, малчин өрхүүдийг дэмжих чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар MNB ТВ, NTV, Ийгл ТВ болон хэвлэл, мэдээллийн бусад байгууллагад гишүүн Л.Отгонтуяа 9 удаа ярилцлага өгсөн бол гишүүн Н.Ууганбаатар МҮОНТ-д 2 удаа, Eagle ТВ-ийн ярилцлагад 1 удаа, news.mn-д 1 удаа Зөвлөлийн чиг үүрэгт хамаарал бүхий сэдвээр ярилцлагад оролцсон. Гишүүн Р.Ринчинбазар Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар судлаачийн байр сууриа илэрхийлж, Eagle телевизэд ярилцлага өгсөн, мөн гишүүн А.Энхбат Монгол Улсын 2025-2027 оны ДХТХМ болон Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн талаар www.surag.mn, www.ubn.mn, www.news.mn, eagle ТВ зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад ярилцлага өгсөн болно.

- ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг УИХ-ын цахим хуудсанд тухай бүр байршуулан нийтэлсэнтэй 545-9410 хүн, нийтэд мэдээлсэн 9 дүгнэлттэй нийт 20,397 иргэн танилцсан байна.

ДӨРӨВ. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд ТТБЗ-ийн дарга, гишүүд төсвийн бодлогын хэрэгжилтээс гадна эдийн засгийн дотоод, гадаад нөхцөл байдал, эрсдэлийг тодорхойлох зорилгоор олон тооны судалгаа хийж, судалгааны ажлууд, тайлантай танилцах ажлыг хийж гүйцэтгэх шаардлага бий болдог. Энэ хүрээнд тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- **Монгол Улсын төсвийн нөхцөл байдлын судалгаа** (2007-2022 он). Энэхүү судалгааг гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа нар хариуцан гүйцэтгэсэн. ТТБЗ-ийн гишүүдэд Дэлгэрсайхан танилцуулга хийсэн. Судалгааны зорилго нь төсвийн бодлогын сүүлийн жилүүдийн хандлага, орлого, зарлага, төсвийн дүрмийн хэрэгжилтийн талаарх нэгдсэн мэдээлэл бэлтгэх явдал байсан.
- **Олон улсын болон Монгол Улсын төсвийн сангуудын судалгаа:** Энэ нь төсвийн сангуудын өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлох зорилгоор баялгийн сан, тогтворжуулалтын сангийн хүрээнд хийгдсэн судалгаа юм. Энэхүү судалгаанд үндэслэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд Зөвлөл саналаа өгсөн болно.
- **Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдлын судалгаа:** Энэ нь ТТБЗ-ийн зүгээс Монгол Улсын 2025-2027 оны ДХТХМ-ийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглал, төлөв байдлын шинжилгээг хийх ажлын хүрээнд төсвийн эрсдэлийн суурь нөхцөлийг тодорхойлох зорилготой хийгдсэн.
- **Монгол Улсын төсвийн эрсдэлийн судалгаа:** Мөн дээрх шинжилгээг хийх хүрээнд Монгол Улсын төсвийн эрсдэлийн өнөөгийн байдал, хандлагыг тодорхойлох зорилготойгоор хийсэн.
- **ДХТХМ-ийн төлөвлөлт, өөрчлөлт, гүйцэтгэлийн шинжилгээ:** Монгол Улсын ДХТХМ-ийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглал, төлөв байдлын шинжилгээг хийх, түүний дагуу 2025-2027 оны макро эдийн засаг, төсвийн гол үзүүлэлтүүдийн таамаглалыг боловсруулах хүрээнд 2012-2023 оны ДХТХМ-ийн тоон үзүүлэлт, өөрчлөлтийг шинжилж, макро эдийн засаг, төсвийн бодлогын чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох зорилготой хийгдсэн.
- **Монгол Улсын гадаад орчин, эрсдэлийн судалгаа:** Энэхүү судалгааг ТТБЗ-ийн макро эдийн засгийн загварт суурилан эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх, загварын тохиргоо хийх, Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдаа, төсвийн бодит нөхцөл байдал, эрсдэлийг тодорхойлох зорилгоор хийсэн. Энэ судалгааны хүрээнд дараах гол эх сурвалжуудыг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын эдийн засгийн тойм. Дэлхийн банкны 2022 оны 4 дүгээр сар, 2023 оны 11 дүгээр сарын тайлан
- Монгол Улсын өрсөлдөх чадварын шинжилгээ. Дэлхийн банкны 2023 оны 12 дугаар сарын тайлан.
- **Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгаа:** Үүнийг ТТБЗ-ийн гаргаж буй макро эдийн засгийн загварын тоон мэдээлэл бэлтгэх, макро эдийн засаг, төсвийн үзүүлэлтүүдийг таамаглахад ашиглах зорилгоор хийсэн. Энэ судалгаанд:
 - Commodity demand outlook 2030 – Minerals Council of Australia
 - Commodity Market Developments and Forecasts-IMF
 - Asia Pacific Consensus Forecasts – Consensus Economic Inc
 - SPECIAL FOCUS Forecasting Industrial Commodity Prices – World Bank
 - Commodity markets outlook october 2022.10 – World Bank
 - Commodity markets outlook october 2023.10 – World Bank
 - Coal 2023 Analysis and forecast to 2026 – International Energy Agency зэрэг эх сурвалжийг ашигласан.
- Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар 2024 оны 5 дугаар сард ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулиас зохион байгуулсан “Газрын тос – 2024” эрдэм шинжилгээний хуралд **“Монгол Энэтхэгийн эдийн засгийн харилцаа”** сэдэвт илтгэл хэлэлцүүлж, 2-р байр эзэлсэн. Мөн 2024 оны 5 дугаар сард Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд **“Эрдэмтний нүдээр PISA”** сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн. Түүнчлэн энэ хугацаанд УИХ-ын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Парламентын судалгаа” эрдэм шинжилгээний сэтгүүлд **“Найман төв, гурван засаг”** нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл, Удирдлагын Академиас эрхлэн гаргадаг “Төрийн удирдлага” онол, арга зүйн сэтгүүлд **“Засаг ба шинжлэх ухаан”** нэртэй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн. Улмаар gogo.mn дээрх өөрийн буланд баялгийн сан болон нийгмийн бусад сэдвээр 4 нийтлэл гаргасан.
- Гишүүн Л.Отгонтуяа **“Монгол Улсад хэрэгжиж буй төсвийн бодлогын хэрэгжилт”** сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 1990-2024 оны буюу 35 жилийн тоон болон чанарын мэдээлэлд тулгуурлан бичиж, Удирдлагын Академийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний илтгэлүүдийн эмхэтгэл номд хэвлүүлж, нийтийн хүртээл болгов.
- Гишүүн А.Энхбат ОУВС-ийн Төв ази болон Монголын сургалтын төвөөс Казакстан Улсын Алма-Аты хотноо 2024 оны 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 4-ний хооронд зохион байгуулсан **“Засаглал ба эмзэг байдал”** сэдэвт сургалтад оролцсон.
- Зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа Asian Association for Public Administration (AAPA), Eastern Regional Organization for Public Administration (EROPA), Indonesian Association for Public Administration (IAPA), Asian Group for Public Administration AGPA хамтран Индонез Улсын Жогжакарта хотод 2024 оны 11 дүгээр сарын 5-7-нд зохион байгуулсан **“Towards World Class Bureaucracy”** сэдэвт олон улсын хуралд илтгэл тавьж оролцов. Хурал дэлхийн 26 орны 1000 гаруй оролцогчид, 250 гаруй илтгэгчид, 7 салбар хуралдаан, 39 панел хэлэлцүүлэгтэй болж, Л.Отгонтуяа, Р.Алтангэрэл, Д.Сүрэнчимэг, П.Бямбасүрэн нарын хамтран бэлтгэж, хэлэлцүүлсэн **“Монгол Улсад жэндэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн туршилага, сургамж”** сэдэвт илтгэл уг хурлын шилдэг 5 илтгэлийн нэгээр шалгарч Asian Review of Public Administration сэтгүүлд нийлэгдэж байгаа болно.
- УИХ-ын даргын зөвлөхийн хүсэлтээр **“Төсвийн цаглавар, төсөв боловсруулах, өргөн барих, хэлэлцэх явцтай холбоотой санал дүгнэлт боловсруулах”** ажилд **“2024 оны төсөв хэлэлцэгдсэн байдал”** сэдвээр гишүүн Н.Ууганбаатар дүгнэлт боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Зөвлөлд хүргүүлсэн.

- 2024 оны төсвийн тодотгол, дагалдах хуулиуд, 2025 оны төсвийн төслийг батлахтай холбоотой асуудлын хүрээнд дүн шинжилгээ хийх ажилд ТТБЗ-ийн зүгээс санал өгөх зорилгоор **Монгол Улсын төсвийн цаглабар, төсвийн эрх зүйн орчны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлохтой** холбоотой судалгааг зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан бусад гишүүдийг оролцуулан хийсэн. Энэ ажлын хүрээнд:
 - Энэ хүрээнд өнөөдөр Монгол Улсын төсвийн цаглабарын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн харьцуулсан судалгааг хийж асуудлыг тодорхойлох;
 - Төсвийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой холбогдох байгууллагуудын дүгнэлтийг судлах.
 - Тухайн асуудлын шийдэлтэй холбоотой олон улсын сайн туршлага, ашиглах боломжит хувилбарыг тодорхойлох
 - Монгол Улсын төсвийн цаглабарын үндсэн асуудлууд, түүний шийдлийг гаргаж, холбогдох хуулийн өөрчлөлтийн саналыг боловсруулах ажлыг гүйцэтгэв.
 - Зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан “Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб”-ээс 2024 оны 9 дүгээр сарын 27-нд зохион байгуулсан “Төсөв-2025” хэлэлцүүлэгт оролцож, төсвийн тэлэлт, төсвийн хөрөнгө оруулалтын талаар байр суурь илэрхийлсэн.
 - УИХТГ-аас 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан “УИХ-ын стратеги төлөвлөгөөний хэлэлцүүлэг”, 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ын дэргэдэх байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “УИХ-ын хяналт шалгалтыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг, сургалтад зөвлөлийн дарга, таван гишүүн оролцож, саналаа илэрхийлсний зэрэгцээ УИХ-ын дэргэдэх байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, тайлан, тайлагналын асуудал дээр багаар ажиллаж, шийдэл санал болгож ажиллав.

Зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар **“Төв, орон нутгийн төсвийн харилцааны нийтлэг асуудлууд, олон улсын жишиг”, “Төсөв хоорондын шилжүүлгийн үр нөлөө”, “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн аргачлалыг боловсронгуй болгох асуудал”** сэдвээр судалгааны ажил гүйцэтгэж, захиалагчдад хүлээлгэн өгсөн.

- **“Төв, орон нутгийн төсвийн харилцааны нийтлэг асуудлууд, олон улсын жишиг”** судалгаанд засаглал хоорондын төсвийн харилцааны талаарх дэлхийн улс орнуудын жишиг хандлагыг зарлага санхүүжилтийн хуваарилалт, орлогын хуваарилалт, Засгийн газрын шилжүүлэг, Нээлттэй уясан тусламж, Хаалттай уясан тусламж, Тусгай зориулалтын ердийн тусламжийн хүрээгээр судлан үзэж, улс орнууд хөгжлийн түвшин, улс төрийн тогтолцооны хэлбэр, туулж ирсэн хөгжлийн замнал, баримталж ирсэн болон баримталж буй хөгжлийн бодлогоос хамаарч төв, орон нутгийн хоорондын хөрөнгийн шилжүүлэг, хуваарилалтыг хэд хэдэн төрөл хэлбэрээр, өөрийн онцлогтоо тохируулан хэрэглэж байгааг жишээ баримтаар харуулсан болно. Олон улсын түвшинд хэрэглэгдэж байгаа төв, орон нутгийн төсвийн хуваарилалтын зарим нийтлэг арга, хэлбэрийг дурдвал:
 - Тухайн муж, орон нутгийн засаг захиргаанд илүү эрх мэдэл, мөн орон нутгийн татвар тогтоох эрх олгох, бие даасан байдлыг хангах, төвөөс хамаарал багатай хөгжүүлэх
 - Төв Засгийн газарт төвлөрсөн төсвийн орлогоос харьцангуй сул хөгжилтэй орон нутгийг илүү дэмжсэн, ялгавартай хуваарилалт хийх
 - Төв Засгийн газраас төсвийн орлогыг хуваарилахдаа үр дүнгийн үзүүлэлтэд тулгуурлах
 - Орон нутгийн засаг захиргаа, мужуудын хооронд хөгжлийн зааг ялгаа бага нөхцөлд үндсэндээ тэгшитгэсэн байдлаар, эсвэл хүн амын тооноос хамааруулан хуваарилах зэрэг төсвийн хуваарилалтын аргуудыг голчлон хэрэглэж байна.
- Судалгааны үр дүнгээс үзвэл төв, орон нутгийн төсвийн харилцааны арга, хэлбэрийг тодорхойлохын тулд дараах үе шатаар асуудалд хандах хэрэгтэй гэж үзсэн. Үүнд:

- *Хуваарилагдах боломжтой хөрөнгө, эх үүсвэрийг тодорхойлох:* Ямар төрлийн орлогоос бүрдсэн, хэдий хэмжээний орлогыг хуваарилах гэж байгааг урьдчилан тодорхойлох шаардлагатай.
- *Төсвийг хуваарилах томъёолол, аргачлалаа сонгох:* Аргачлал, томъёо нь тухайн орон нутгийн хэрэгцээ, чадавх, боломж нөөц гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтээс хамаарсан байх нь зохимжтой.
- *Хөрөнгө хуваарилахад баримтлах шалгуур нөхцөлүүдийг тодорхойлох:* Үүнд төсвийн зардлын нөхцөл (Марокко, Колумби), үр дүнгийн нөхцөл (Австрали, Канад) хамаарна.
- **“Төсөв хоорондын шилжүүлгийн үр нөлөө”** судалгаагаар төв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд Орон нутгийн санхүүгийн үйл ажиллагааны загвар, Төсвийн тэнцлийг хангах хөрөнгийн эх үүсвэрт хязгаарлалт тавихгүй байхаар тооцсон загвар, Нөөцийн хязгаармагдмал байдлыг тооцож улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг хуваарилах загвар, Орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлэх загвар, Кобб-Дугласын хэлбэрийн зорилгын функц ашигласан загварыг тус тус боловсруулж, Орон нутгийн орлого, зарлагын оновчтой утгын шинжилгээ, Орон нутгийн засаг захиргааны оновчтой сонголт төсвийн орлого, зарлагын зөрүүг нөхөх хувиас хамаарах асуудлыг судлан үр дүнг график, схем, хавсралтаар харуулсан.
- Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо, санхүүжилтийг тооцох аргачлалыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах зорилгоор **“Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн аргачлалыг боловсруулах болгох асуудал”** сэдэвт судалгааны төслийг удирдан гүйцэтгэж, дараах судалгаа, тайлангуудыг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Үүнд:
 - Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээнд хамрагдах өвчлөлийн ангиллын судалгаа
 - Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний тарифын судалгаа, зөвлөмж
 - Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, төв эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдийн үйлчилгээний процессын зураглал
 - Төсвийн аргачлалуудыг нь хянах гүйцэтгэлийн болон чанарын үзүүлэлтүүд
 - Төслийн нэгдсэн тайлан.
- Эрүүл мэндийн салбар нь Засгийн газрын төсвийн 10 хувийг эзэлдэг бөгөөд өнгөрсөн хугацаанд төсвийг жил бүр нэмэгдүүлж баталж байгаа хэдий ч эрүүл мэндийн салбарын үр дүнтэй шууд уялдаагүйгээс гадна тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмж, чанар нь жил бүр төсөв боловсруулж буй үйл явцтай нийцэхгүй байна. Иймд төсвийг боловсруулахдаа үр дүнд суурилж тооцдог байх, үр ашигтай байхаар төлөвлөдөг байх, эрүүл мэндийн байгууллагууд нь үйл ажиллагаагаа сайжруулж, өгч буй төсвийг үр ашигтай зарцуулдаг байх, зарцуулсан төсвийн үр дүнг нь тогтмол хэмжиж тайлагнадаг байх зэрэг асуудлыг хөндөн тавьсан.
- Судалгааны хүрээнд ЭМД-ын сангаас санхүүждэггүй боловч улсын төсвөөс хариуцдаг эх барих, халдварт өвчин, яаралтай тусламж, түргэн тусламж, хорт хавдар, сэтгэц зэрэг тусламж, үйлчилгээний өртгийг тооцож, тухайн тусламж, үйлчилгээг эмнэлзүйн хувьд төсөөтэй болон өвчний хувьд ойролцоо байдлаар бүлэглэж 105 оношийн хамааралтай бүлэг болгон санхүүжүүлэх боломжтой гэдгийг тодорхойлсон. Ингэснээр эмнэлгүүдийг үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон түүний тарифт үндэслэн төсвийг боловсруулж, тухайн төсвөөр үзүүлж буй тусламж, үйлчилгээний үр дүн, түүний ашиглалтыг хэмжих боломжийг бий болгосон. Түүнчлэн тухайн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх анхан шатны тусламж, үйлчилгээний 2 бүлгийн 54, эмнэлгийн тусламж, үйлчилгээний 11 бүлгийн 78 шалгуур үзүүлэлт боловсруулсны дагуу ашиглах

боломжтой гэж үзлээ. Судалгааны үр дүн эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны реформ хийхэд суурь үндэс болно гэж үзэж байна.

ТАВ. ЗӨВЛӨЛИЙН ДОТООД АЖИЛ

- УИХ-ын дарга Г.Занданшатартай 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хийсэн уулзалтад Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны дарга нар, ТТБЗ-ийн бүх гишүүд оролцож, цаашид эдийн засаг, төсөв, санхүүгийн мэдээллийг харилцан солилцох, судалгаа хийх, макро-төсвийн бодлогын загвар боловсруулахад хамтран ажиллах талаар үүрэг даалгавар, чиглэл авсан болно.
- УИХ-ын дарга Г.Занданшатар ТТБЗ-ийн гишүүдтэй 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хийсэн уулзалтын дараа ТБХ-ны дарга Г.Тэмүүлэн, ахлах зөвлөх Алтанзул нартай уулзаж, ТТБЗ хэрхэн үйл ажиллагаагаа явуулах талаар санал солилцов.
- Шинээр байгуулагдсан ТТБЗ-ийн анхны хурал 2024 оны 1 дүгээр сарын 22-ны 10 цагт Төрийн ордны Үндсэн хууль танхимд болж, ТТБЗ-ийн даргыг сонгох сонгууль болов. Гишүүд алтернатив хувилбар дэвшүүлж, санал хураалтыг явуулсан. Гишүүд ТТБЗ-ийн хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, журам, өмнөх ТТБЗ-ийн 2018-2023 оны тайланг хүлээн авч, уншиж танилцсан.
- Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар 2024 оны 2 сард шинээр байгуулагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн бэлгэ тэмдгийн загварыг боловсруулж зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Бэлгэ тэмдэгтэй хамт “Хоосрохуйд урьдаар ухаан барагдана” гэсэн уриаг мөн санал болгосон.
- ТТБЗ-ийн ажиллах албан тасалгаатай танилцаж, тус өрөөг тохижуулах талаар Зөвлөлийн гишүүдтэй ярилцаж, саналаа (2024.01.23-01.30) нэгтгэсэн болно. 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Мишээл экспо төвд худалдаалж буй оффисын тавилгыг үзэж судлан ТТБЗ-ийн оффист ашиглах номын болон хувцасны шкаф, шүүгээ, буйдан, сандал, сэтгүүлийн ширээ зэргийн захиалгыг BSB компанид өгөх ажлыг гишүүн Л.Отгонтуяа Ажлын албаны референт Б.Одмандахын хамт гүйцэтгэв. Түүнчлэн тэрээр ТТБЗ-ийн гишүүдийн албан хэрэгцээний компьютер худалдан авах, гэрээ байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад холбогдох зөвлөгөөг өгч ажилласан болно.
- ТТБЗ-ийн дарга, гишүүдийн анхны уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр хийж, 2024 оны ажлын төлөвлөгөө боловсруулах талаар хэлэлцэж, Зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан нарт үүрэг болгосны дагуу ТТБЗ-ийн ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Зөвлөлөөр хэлэлцэн эцэслэн баталсан.
- ТБХ-ны дарга Г.Тэмүүлэн ТТБЗ-ийн ажлын өрөөнд 2024 оны 2 дугаар сарын 8-ны өдөр хүрэлцэн ирж Зөвлөлийн дарга, гишүүдтэй уулзалт хийж, Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ойрын хугацаанд хийх гэж байгаа ажлуудтай танилцаж, харилцан санал, бодлоо солилцсон.
- Австри улсад 2022 онд УИХ, ТТБЗ, ЗГХЭГ, СЯ-ны төлөөллийн хийсэн сургалт-айлчлалын нэгтгэсэн танилцуулга слайдыг гишүүн Л.Отгонтуяа бэлтгэн ТТБЗ-ийн бүх гишүүдэд хүргүүлсэн, мөн 2021 онд ТТБЗ-ийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ажилласан дотоодын зөвлөхийн бэлтгэсэн дэлхийн улс орнуудад ажиллаж буй Төсвийн зөвлөлүүдийн талаарх мэдээллийг Зөвлөлийн цахим группт байршуулсантай гишүүд танилцсан болно.
- НҮБХХ-ийн Ажлын хэсэгтэй 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр уулзаж Монгол Улсын нөхцөл байдал, шаардлагад тулгуурлан дунд хугацааны төсвийн хүрээний тогтолцоонд шилжих төлөвлөгөөний хувилбарууд боловсруулах талаар санал

солилцсон. Мөн төсвийн хүрээний мэдэгдлийн одоогийн нөхцөл дэх сорилтууд, макро загварчлалын чадавх, түүний хөгжүүлэлтийн талаар санал солилцсон.

- НҮБХХ-ийн төслийн менежер Б.Нинжин, зөвлөх Т.Золбоо, Ц.Сэлэнгэ нартай 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр уулзалт хийж, макро эдийн засгийн төсөөллийн загварчлал боловсруулах чиглэлээр судалгаа хийх, хэрэглэж буй загварыг хөгжүүлэх талаар судалгааны ажил эхлүүлэхээр тохиролцсон.
- НҮБХХ-ийн зөвлөх Ц.Сэлэнгэ макро эдийн засгийн дөрвөн загварыг харьцуулан судалж, эдгээрээс манай орны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцэх, олон улсын судалгаа, практикт судлагдсан Dignar, Dignad зэрэг загварыг Зөвлөлийн үйл ажиллагаанд тохирох загвараар сонгож, 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр танилцуулсан. Мөн НҮБХХ-ийн зөвлөх Т.Золбоо, С.Сүхдэлгэр, Б.Эрдэнэбат, Г.Хулан нартай дунд хугацааны төсвийн хүрээг хэрэгжүүлэх замын зураглалын талаар ярилцаж, харилцан санал солилцсон.
- Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн таамаг боловсруулах болон бодлогын нөлөөг шинжлэхэд зориулан боловсруулж буй динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загварыг сайжруулах хүрээнд 2024 оны 9-12 дугаар сард "DSGE models with DYNARE-Matlab" сэдэвт семинарыг долоо хоног бүр тогтмол удирдан явуулсан.
- Шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд зориулан “Төсвийн тухай мэдээлэл” сэдэвт танилцуулгыг гишүүн Н.Ууганбаатар хариуцан бэлтгэж, Зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлж, УИХ-ын гишүүдэд 2024 оны 8 дугаар сарын 9-ний өдөр хүргүүлсэн.
- Тайлант хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 20 байгууллага, албан тушаалтанд нийт 75 албан бичгийг хүргүүлж ажиллалаа (Хавсралт 2).

ЗУРГАА. ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

Зөвлөлийн гишүүн А.Энхбат ТТБЗ-ийн 2024-2028 оны стратегийн баримт бичгийн төслийг санаачлан боловсруулж, 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр бүх гишүүдэд танилцуулж, гишүүдийн саналыг авч ТТБЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын салбарын төсөв, санхүүгийн сайн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд дэлхийн олон улс оронд төсөв, санхүүгийн томоохон шинэчлэл, өөрчлөлт хийгдэж байна. Ялангуяа 2008-2009 оны санхүүгийн хямрал, 2019-2022 оны цар тахлын дараа улс орныхоо төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, энэ хүрээнд төсвийн сайн дүрэм, журамтай болох, түүнийг хэрэгжүүлэх, төсвийг тогтвортой байлгах институц бүрдүүлэх зорилго нэн тэргүүнд тавигдах болжээ. Ийнхүү төсвийн хариуцлагын, эсвэл тогтвортой байдлын тухай хууль эрх зүйн орчныг бий болгох замаар төсвийн сахилга батыг сайжруулах, нөөцийг үр ашигтай, үр дүнтэй хуваарилах зорилгоор ТТБЗ-ийг шинээр байгуулах асуудал дэлхийн улс оронд хүрээгээ тэлж байна.

ОУВС-аас энэ байгууллагыг “Олон талын чиг үүрэг бүхий төсвийн бодлогод итгэх итгэлийг бэхжүүлэх нийтийн санхүүгийн хяналтыг хариуцдаг аль нэг нам бус, техникийн байгууллага, төрийн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахтай холбоотой макро эдийн засгийн зорилтуудтай уялдуулан төрийн санхүүгийн бодлого, төлөвлөгөө, гүйцэтгэлийг улс төрийн намын нөлөөллөөс хараат бусаар олон нийтэд, богино хугацаанд үнэлж дүгнэх эрх бүхий байнгын ажиллагаатай агентлаг” гэж тодорхойлсон байдаг.

Манай улсын хувьд төрийн санхүү, төсвийн эрх зүйн шинэчлэл хийх үйл явц 2008 оноос эхлэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр Үндсэн хууль, холбогдох бусад органик хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх ажлууд хийгдэж

байгаа юм. Анх удаа төсвийн хариуцлагын талаар буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд, Төсвийн тухай хуулийг 2011 онд, Өрийн удирдлагын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийг тус тус 2015 онд, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 2016 онд УИХ-аар баталж, мөрдүүлсэн билээ.

Засгийн газраас төсвийг боловсруулах үйл явцад төсвийг дунд хугацаагаар төлөвлөх шинэ элементийг нэвтрүүлэн 2013 оноос ДХТХМ-ийг боловсруулж эхлэн УИХ-аар хэлэлцэн хуульчлан баталдаг болсон. Ингэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн дүрэм буюу тусгай шаардлагыг хангасан байдлаар төсвийн төслийг боловсруулдаг болсноор төсвийн сахилга батыг сахиулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах чиглэлд томоохон өөрчлөлт, ахиц дэвшил бий болов.

Гэсэн ч сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн бүтцэд уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ ихсэхийн хэрээр эдийн засгийн суурь суларч гадаад зах зээлээс хэт хамааралтай болж, улсын төсвийн орлого, зарлага тогтвортой бус, хэлбэлзэл ихтэй, гадаад өрийн хэмжээ их, үе үеийн УИХ, Засгийн газрууд хуулиар баталсан төсвийн дүрмүүдээ удаа дараа дур мэдэн өөрчлөх болсон нь макро эдийн засгийн тогтворжилт болон төсвийн тогтвортой байдал алдагдах шалтгаан болов. Тухайлбал, 2011-2023 оны хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 14 удаа, Төсвийн хүрээний мэдэгдэлд 20 удаа нэмэлт өөрчлөлтийг оруулж байсан.

Энэ бүхэн УИХ болон Засгийн газрын төсвийн хүрээнд үүсгэсэн тогтворгүй үр дүнг дахин гаргуулахгүй байх зорилгоор ТТБЗ-ийг байгуулах гол үндэс болсон юм.

Монгол Улс ОУВС-тай 2017 онд “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд ТТБЗ-ийг байгуулах үүрэг хүлээж, УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 83 дугаар тогтоолоор зөвлөлийг байгуулж, дүрмийг нь баталсан. ТТБЗ-ийн статус болон үйл ажиллагаа хуулиар баталгаажсан нь төсвийн шинэчлэлийн том алхам болжээ. Нөгөө талаар эдийн засаг, төсвийн үйл явцад илүү хяналт, илүү ил тод байдлыг бий болгохын тулд итгэл хүлээсэн бие даасан төсвийн институт бий болгох шаардлагатай байна.

УИХ-аар 2017 онд байгуулагдсан ТТБЗ нь даргаас бусад гишүүд нь орон тооны бус ажиллаж байсан бөгөөд улмаар улс төрийн тодорхой дэмжлэгийн хүрээнд 2023 оны 7 дугаар сард Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж орон тооны 7 гишүүнтэйгээр бие даасан, хараат бус төрийн байгууллага хэлбэртэйгээр байгуулан 2024 оны 2 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

ТТБЗ-д хуулиар олгогдсон өнөөгийн эрх хэмжээг өргөн утгаар авч үзвэл төсвийн тусгай шаардлагын үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, макро эдийн засаг, төсвийн төсөөллийн найдвартай, үнэн бодит байдлыг баталгаажуулах, орон тооны судалгааны нэгжтэй байх, иргэд олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харьцах зэрэг олон улсын Төсвийн зөвлөлүүдийн жишиг загвартай нийцэж байна.

Цаашид ТТБЗ-ийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус, нам бус, мэргэжлийн байх үндсэн зарчмуудыг хангах, байгууллагын хувьд бэхжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгоор дунд хугацааны Стратегийн баримт бичгийг боловсруулж гаргах зайлшгүй шаардлага тулгарсан юм.

Дэлхийн бусад улс орнуудын улсын салбарын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцооны хөгжлийн чиг хандлага, манай улсын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, макро эдийн засгийн бодлого, төсвийн бодлогын өнөөгийн орчныг судалсны үндсэн дээр бидний өмнө тулгамдаад буй дор дурдсан асуудлуудыг шийдвэрлэхэд “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн стратегийн баримт бичиг 2024-2028”-ын үндсэн зорилго оршиж байна. Үүнд:

- Монгол Улсын макро эдийн засгийн болон төсвийн тогтворгүй байдал, төсвийн зарлагын тэлэлт, гадаад өр болон ядуурал, ажилгүйдлийн түвшин зэрэг асуудлууд төсвийн өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой. Нэг талаас улс орны хөгжлийн зөв

бодлого, төлөвлөлт, макро эдийн засаг болон төсвийг тогтвортой байлгахад улс төрийн оролцоо, нөлөөг багасгах, нөгөө талаас Засгийн газрын боловсруулсан дунд хугацааны төсөв, санхүүгийн бодлогод бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагын үнэлгээг хангах зайлшгүй шаардлагатай. Иймээс ТТБЗ-ийн хараат бус, бие даасан, нам бус, мэргэжлийн институцыг бэхжүүлэх, дунд болон урт хугацаанд эрх зүйн орчныг баталгаажуулан, сайжруулах нь тулгамдаж буй асуудлыг зөв шийдвэрлэх эхний алхам болно.

- ТТБЗ хуулиар хүлээсэн эрхлэх асуудлынхаа хүрээнд ДХТХМ-ийн төсөөлөл болон жилийн төсвийн төсөлд шинжилгээ хийх, Засгийн газраас боловсруулсан төсвийн төсөл төсвийн тусгай шаардлагуудыг хангасан эсэхэд шинжилгээ хийх шаардлага тулгарч байгаа тул шинжлэх ухааны үндэслэлтэй суурь судалгаа хийх, эдийн засаг-математикийн загваруудыг хөгжүүлэх асуудал дараагийн чухал алхам болж байна.
- ТТБЗ-ийн хүний нөөцийг бүрдүүлэх, бэхжүүлэх, тэдний чадавхыг сайжруулах асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. ТТБЗ нь 2025 оноос 7 хүний бүрэлдэхүүнтэй чадварлаг мэргэжилтнүүдээс бүрдсэн Судалгааны нэгжтэй байх боломж нөхцөл бүрдсэн. Цаашид макро-эдийн засаг, төсвийн төсөөллийг боловсруулах загварчлал, арга зүй, техникийг эзэмшүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр ТТБЗ-ийн одоо байгаа болон ирээдүйн гишүүд, ажилтнуудыг чадавхжуулах, үүнд Олон улсын байгууллагуудын туслалцааг авах зайлшгүй шаардлага үүснэ.
- ТТБЗ-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, төсвийн сахилга бат, ил тод, үр нөлөөтэй байдлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хүргэх, ингэснээр өөрийн нөлөө, нөлөөллийг нийгэмд болон УИХ, Засгийн газар, түүний байгууллагуудад бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ингэхийн тулд ТТБЗ өөрийн домэйн веб хуудас, портал сайттай болох, нийгмийн цахим бусад арга хэрэгсэл (twitter, facebook, telegram гэх мэт)-ийг ашиглах хэрэгтэй болно.

Стратеги төлөвлөгөөний эдгээр зорилгыг амжилттай хэрэгжүүлэх арга хэрэгслээ буюу зорилгоо дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

1. ТТБЗ-ийг институцийн хувьд бэхжүүлэх, хууль эрх зүйн хүрээнд улам сайжруулах
2. Шинжлэх ухааны үндэслэлтэй суурь судалгаа, шинжилгээ хийх, загварыг хөгжүүлэх
3. ТТБЗ-ийн гишүүд, ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх
4. ТТБЗ-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, ил тод, нээлттэй байдлыг бий болгох, хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах харилцааг бий болгох гэх мэт.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд ТТБЗ цаашид үр дүнтэй, амжилттай ажиллах нь төсвийн хуулийн хүрээнд тусгайлан тодорхой заасан бүрэн эрх, энэхүү эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хангалттай хүн хүч, санхүүгийн нөөц боломж, өндөр чадавх бүхий боловсон хүчнийг сонгон олж, тогтвортой ажиллуулах, Засгийн газрын байгууллагаас чухал хэрэгцээт мэдээллийг цаг тухайд нь олж авах баталгаатай болох зэрэг гол хүчин зүйлсээс шалтгаалах болно. ТТБЗ-ийн дарга, зөвлөлийн гишүүд нь ТТБЗ-ийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд манлайлж, байгууллагын судалгаа, шинжилгээ, тайлангийн чанарыг баталгаажуулж, гол оролцогч талуудтай харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлж, ТТБЗ-ийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, зааж сургах үүрэгтэй байвал зохино гэж үзсэн.

Түүнчлэн УИХ болон түүний харьяа байгууллагууд (Монголбанк, ҮСГ, СЗХ, ҮАГ), мөн Засгийн газар болон түүний яам, агетлагууд (СЯ, ЭЗХЯ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар) -тай хамтран ажиллах Санамж бичиг байгуулан (одоогоор МБ болон СЯ-тай гэрээ байгуулсан байгаа) мэдээлэл олж авах, туршлага, мэдлэг, шинжилгээний аливаа ажлаа уялдуулах, мэргэжилтэн ажилтнуудынхаа чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Эдгээр шаардлага, үндэслэлийг тусгасан Стратегийн баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.

ДОЛОО. БУСАД АЖИЛ

ТТБЗ-ийн гишүүн Р.Ринчинбазар УИХ-ын Төсвийн байнгын хорооноос санаачлан боловсруулсан “Нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих татварын бодлогын тухай” хуулийн төсөлд тусгах тодорхой саналуудыг гаргаж, Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Тухайлбал, хуулийн төслийн 4.1.8-д “захиргааны болон үйл ажиллагааны зардал бага байх” гэж татвар хураалтын зардал нь уг татварын орлогоос бага байхыг; татварын үр ашигтай байх зарчмын дагуу тухайн төрлийн татвар хураалтын зардал нь татварын орлогын хоёр хувиас хэтрэхгүй байхыг; 4.1.9-д “төвийг сахисан байх” гэж татварын бодлогоор дамжуулж хэрэглээ болон бүтээгдэхүүний онцлогт гажилт үүсгэхгүй байхыг; 4.1.10-т “Тэгш шударга байх байх” гэж ижил хэмжээний орлого олсон ижил төрлийн татвар ногдох зүйлтэй этгээдүүдийг татварын харилцаанд ижил тэгш оролцуулахыг хэвтээ тэгш шударга байдал, ижил биш хэмжээний орлоготой этгээдүүдэд ялгаатай хэмжээгээр татвар ногдуулах зарчмыг баримталж татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулж татвар төлөгчдөд ялгаатай хандахгүй байхыг; 6.5-д Татварын дэмжих бодлого нь дараах хэлбэртэй байх ба Засгийн газар нь холбогдох дэмжлэгийн хувилбарыг энэ хуульд нийцүүлэн боловсруулна, 6.6.1-д байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хэрэглээнд өндөр татвар ногдуулах, 6.6.2-т орчныг /агаар, ус, хөрс.../ бохирдуулах эх үүсвэр, үйл ажиллагаанд татвар ногдуулах, 7.1.5-д ажилтны цалингийн орлогоос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний орлогыг татвараас чөлөөлөх, эрүүл мэндийн болон хүүхдийн боловсролын зардал, гэр бүлийн асаргаа шаардлагатай өрхийн гишүүн асрах, орон сууцны зээлийн хүү төлөх гэх мэт зардлыг цалинд татвар ногдуулах сууриас хасаж тооцоолох замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжийг хумих; 7.1.6-д Хөдөлмөрийн чадвараа 50% ба түүнээс дээш хувиар алдсан ажил хөдөлмөр эрхлэлтийн орлогыг татвараас чөлөөлөх замаар хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжинэ (Одоо бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гээд бас бүх орлогыг хамаатуулснаар гэр бүлийн гишүүд нь татвараас зайлсхийх боломж олгоод байгаа), 8.1.5-д хотын төвийн бүсэд байрлах үл хөдлөх эд хөрөнгө, газрын төлбөрийн үнэлгээг нэмэгдүүлж, холбогдох татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх (Ижил байршилд эдийн засгийн ач холбогдол ойролцоо хөрөнгийн үнэлгээнд татварын тэгш шударга байх зарчмыг хангахуйц татвар тооцох үнэлгээний аргагүй нэвтрүүлэх), 12.1.9-д үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор демпингийн эсрэг татварын бодлогыг нэвтрүүлэх (Энэ нь дотоодын барааны үнийг өсгөх сөрөг нөлөө үзүүлээд байгаа) зэрэг өөрчлөлт хийж болох тухай санал өгсөн болно.

Мөн энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор татварын бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар бодлогын судалгаа хийж, энэ хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татвар, Дотоодын үйлдвэрлэл, ажил үйлчилгээнд ногдуулах НӨАТ, Импортын бараа, бүтээгдэхүүнд ногдуулах НӨАТ, Орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл болон татварын шинэтгэлийн бусад асуудлын талаар хөндөж, тодорхой саналуудыг дэвшүүлсэн.

Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар тайлант хугацаанд УИХ, ЗГХЭГ-ын дарга болон ХХААХҮ-ийн сайдын тушаалаар дараах 3 ажлын хэсэгт томилогдон ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газраас өргөн барьсан “Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай” хуулийн төслийг байнгын хороод болон чуулганы хуралдаанд бэлтгэхээр 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр байгуулагдсан ажлын дэд хэсгийн гишүүн (УИХ);
- “Турилыг гаалийн алган татвараас чөлөөлснөөр дотоодын гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэд гарах нөлөөллийг судалж танилцуулах”-аар 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн (ЗГХЭГ);
- “2024 оны улаан буудайн өртгийн судалгааг хийх, үнэ тогтоох” үүрэг бүхий 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн (ХХААХҮЯ).
- УИХ-аас 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Үндсэн Хууль 100” арга хэмжээний хүрээнд “Үндсэн хуульт ёс: Өнгөрсөн, одоо, ирээдүй” олон улсын эрдэм

шинжилгээний хурлын “Үндсэн хуулийн эдийн засаг ба гүйцэтгэх эрх мэдэл” салбар хуралдаанд чиглүүлэгчээр ажилласан.

- Иманнуэл Кантын мэндэлсний 300 жилийн ойн хүрээнд Социал Демократ Монголын Залуучуудын Холбооноос зохион явуулсан “Кант 300: Нээлттэй уулзалт хэлэлцүүлэг”-т “Кант ба Математик” сэдвээр илтгэл тавьсан.
- Science Café UB-ээс 2024 оны 8 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Sci-Teach форум 2024” хэлэлцүүлэгт панелистаар оролцсон.

Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, А.Энхбат, Ажлын албаны референт Б.Одмандах нар ОУВС-ийн Төв Ази болон Монголын сургалтын төв, ЭЗХЯ хамтран Улаанбаатар хотноо 2024 оны 9 дүгээр сарын 11-18-ны хооронд зохион байгуулсан “Mongolia: National Workshop on Macroeconomic Analysis/Financial Programming and Policies” сэдэвт сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

Гишүүн А.Энхбат ОУВС-ийн Төв Ази болон Монголын сургалтын төвөөс Казакстан Улсын Алма-Аты хотноо 2024 оны 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 4-ний хооронд зохион байгуулсан “Засаглал ба эмзэг байдал” сэдэвт сургалтад оролцсон.

НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ЗОРИЛТ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2024 оноос эхлэн байнгын ажиллагаатай, орон тооны 7 гишүүнтэйгээр ажиллан хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, дараах үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Зөвлөл 2024 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд буюу төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн эрсдэлээс сэргийлэх, төсвийн ил тод байдлыг сайжруулах чиглэлд идэвхтэй ажиллаж, нийт 12 удаа тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргаж, УИХ, ТБХ, ЭЗХЯ, Сангийн яаманд хүргүүлэв. Гэхдээ төсвийн сахилга батыг сулруулах, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй зохицуулалтууд байгааг онцолж, төрийн санхүүгийн хариуцлагатай бодлого баримтлахыг анхааруулсаар байгаа юм.

УИХ-ын чуулганы хуралдаан, Төсвийн байнгын хороо, Зарлагын хяналтын дэд хороо, холбогдох ажлын хэсгүүд, намын бүлгийн хурлаар ТТБЗ-ийн дарга, гишүүдийг байлцуулан Зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг сонсож, асуулт асууж, хариулт авахын зэрэгцээ санал, бодлоо солилцож, УИХ-ын чуулганы хуралдаан дээр өөрсдийн тавьж буй асуулт, саналдаа Зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэл болгодог УИХ-ын гишүүдийн тоо нэмэгдсэн болно. Иргэд, олон нийт ч Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, судалдаг болж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагад Засгийн газрын саналын дагуу УИХ зарим өөрчлөлтийг оруулсан хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс 2025 оны төсөвт бүхэлд нь хориг тавьсны дараагаар Засгийн газар уг төсвийн төслийг алдагдалгүй байхаар дахин өргөн барьж, УИХ анх удаа алдагдалгүй төсөв баталсан нь чухал ололт гэж үзэх үндэстэй.

Зөвлөлийн үйл ажиллагааны нэг үр дүн нь Төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн таамаглал, төлөв байдлын төсөөллийг бэлтгэхийн тулд Дигнар, САЕМ загваруудыг Монгол Улсын онцлогт тохируулан ашиглах боломжтой болгосон явдал юм. Зөвлөлөөс 2024 оны 3 дугаар сард 2025-2027 оны макро-төсвийн таамаглалыг боловсруулахдаа тооцоолж гаргасан ДНБ-ий 2024 оны бодит өсөлтийн дээд, доод (Хавсралт 1) түвшнээр тооцсон төсөөллийн дундаж үзүүлэлт нь 2024 оны урьдчилсан гүйцэтгэлтэй ойролцоо (Хавсралт 4) байгаа нь үүний илрэл гэж болно. Зөвлөлөөс макро эдийн засгийн таамаглал боловсруулах, чадавхыг бэхжүүлэхэд НҮБХХ болон ОУВС-ийн дэмжлэг бодитой хувь нэмэр оруулж байгааг дурдах нь зүйтэй.

ТТБЗ-ийн зүгээс 2025 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллах болно. Үүнд:

- Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд ДХТХМ-ийн төсөөлөл болон Засгийн газраас боловсруулсан жилийн төлөвлөгөө, төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагуудыг хангасан эсэхэд шинжилгээ хийх, дүгнэлт өгөх шаардлага тулгарч байгаа тул шинжлэх ухааны үндэслэлтэй суурь судалгаа хийх, макро-төсвийн загваруудыг илүү сайжруулан хөгжүүлэх;
- Зөвлөл нь 2025 оноос 7 хүний бүрэлдэхүүнтэй чадварлаг мэргэжилтнүүд, мэргэшсэн судлаачдаас бүрдсэн Төсвийн судалгааны нэгжтэй байх эрх зүйн зохицуулалттай болсон тул хүний нөөцийг бүрдүүлж, олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаанд тулгуурлан макро-эдийн засаг, төсвийн төсөөллийг боловсруулах загварчлал, арга зүй, техник эзэмшүүлэх, гүнзгийрүүлэн мэргэшүүлэх, чадавхыг бэхжүүлэх, цаашид тогтвортой ажиллуулахад анхаарах;
- ТТБЗ-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, төсвийн сахилга бат, ил тод, үр нөлөөтэй байдлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илүү өргөн хүрээнд мэдээлэх, хүргэхийн тулд өөрийн домэйн хаяг, веб хуудас, портал сайттай болох, нийгмийн цахим бусад арга хэрэгсэл (twitter, facebook, telegram гэх мэт)-ийг ашиглах;
- Засгийн газрын байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг тухай бүрд нь цуглуулж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн албан хэрэгцээнд ашиглах зорилттой ажиллаж байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Хавсралт 1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал

Хавсралт 1.1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалын дээд хязгаар

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Таамаглалын дээд хязгаар		
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.7	7.7	7.6
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	8.0
3	Нэгдсэн төсвийн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	26,170.2	28,360.0	31,123.2
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	25.9	24.5	23.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	27,774.0	30,946.3	34,353.5
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27.5	26.7	25.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	413.5	3,172.3	3,407.2
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.4	2.7	2.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,020.0	-2,320.0	-2,660.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,999.8	6,805.7	8,764.4
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.0	5.9	6.6
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	60,600.0	69,600.0	79,800.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,727.0	3,132.0	3,591.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.7	2.7	2.7

Хавсралт 1.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалын доод хязгаар

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Таамаглалын доод хязгаар		
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	3.1	4.1	4.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.4	6.3
3	Нэгдсэн төсвийн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	24,323.1	26,624.1	29,220.4
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	24.1	23.0	22.0
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	25,814.6	29,054.5	32,253.6
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	25.6	25.1	24.3
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	384.3	2,978.1	3,198.9
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.4	2.6	2.4
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,020.0	-1,740.0	-1,330.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-1.5	-1.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,646.9	6,389.1	8,228.6
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.6	5.5	6.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	55,550.0	60,900.0	66,500.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.0	52.5	50.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,525.0	2,668.0	2,793.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	2.3	2.1

Хавсралт 2. Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд оруулсан өөрчлөлт

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010.06.24)	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (2024.08.12)	Өөрчлөлт +/- байдал
1	12.1.1.дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ;	12.1.1.дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ;	Өөрчлөлтгүй
2	12.1.2.хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;	12.1.2.хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;	Өөрчлөлтгүй
3	12.1.3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ;	12.1.3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн доод орлогын хэмжээ;	Хуулийн төслийн нэмэлт өөрчлөлтөөр 12.1.3-д “доод” гэж нэмсэн.
4	12.1.4.нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ;	12.1.4.нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ;	Өөрчлөлтгүй
5	12.1.5.нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ;	12.1.5.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	Өмнөх хуулийн 12.1.6-д байсныг 12.1.5 болгон өөрчлөлт хийж, харин 12.1.5-д байсан “нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хэмжээ” гэсэн заалтыг хассан.
6	12.1.6.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл;	12.1.6. Нэгдсэн төсвийн суурь зарлагын хэмжээ	Өмнөх хуулийн 12.1.5-д заасан “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ” гэснийг 12.1.6 болгон “нэгдсэн төсвийн зарлагын хэмжээ” гэж өөрчлөн “өсөлтийн” гэснийг хассан
7	12.1.7.нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ;	12.1.7.нэгдсэн төсвийн суурь тэнцэл	Өмнөх хуулийн 12.1.7-д заасан “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ” гэснийг хасаж, “нэгдсэн төсвийн суурь тэнцэл” гэсэн шинэ томъёолол гаргаж оруулсан.
8	12.1.8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ;	12.1.8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ;	Өөрчлөлтгүй
9	12.1.9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ.	12.1.9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ.	Өөрчлөлтгүй

Хавсралт 3. Монгол Улсын төсвийн 1990-2024 оны төлөв байдал


Төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ аливаа улс орон нэн тэргүүнд төсвийн бодит нийт орлогодоо багтааж зардлаа гаргах (дотоод орлого болон гадаад зээлийн тогтвортой хэмжээний хүрээнд), үүний тулд төсвийн зарлагыг тогтвортой хязгаарт барих, улсын өр ба зээлийн хязгаарыг тогтоох шаардлагатай болдог. Уг шаардлагыг хангахын тулд Засгийн газар чиг үүргээ оновчтой тодорхойлон хуваарилж, түүнийг хэрэгжүүлэх төсвийг удирдлагын түвшин бүрээр зааглан тогтоож, хуульчлан баталгаажуулж (Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хууль), төсвийн дунд хугацааны хүрээ, жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн захирагчид хэрхэн ажиллаж буйг төсвийн хяналтын хэлбэр (төрийн аудит, санхүүгийн хяналт, дотоод аудит, төрийн сангийн хяналт)-үүдийг ашиглан хянаж ажилладаг.

Иймээс Монгол Улсын төрөөс төсвийн орлого, зарлагын уялдааг хангаж буй байдал, 1990-2024 оны төсвийн нийт орлого, зарлага, тэнцэл, улсын өр, зээлийн байдалд харьцуулсан болон бүтцийн өөрчлөлтийн шинжилгээ хийлээ.

Нэгдсэн төсвийн нийт орлого, зарлага, тэнцэл: Нэгдсэн төсвийн орлого, зарлага, нийт тэнцлийн динамикийг сүүлийн 35 жилийн байдлаар Зураг 1-д харуулав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн төсвийн тэнцэл нь анх 2005 онд ашигтай гарснаас хойш энэ байдал 2006, 2007 онд давтагдсан боловч 2008, 2009 оны төсвийн гүйцэтгэлээр алдагдалтай гарч 2010 онд 41.8 тэрбум төгрөгийн ашигтай байсан ч 2011 оноос алдагдлын хэмжээ эрс нэмэгдэж, 2016 онд 3.7 их наяд төгрөг болж нэмэгдсэн, харин 2018 онд 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.


Зураг 1. Нэгдсэн төсвийн 1990-2025 оны нийт орлого, зарлага, тэнцэл (оны үнээр), тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хорооны мэдээлэл, 1990-2025 он

Төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг оны үнээр харьцуулахаас илүүтэй ДНБ-д эзлэх хувиар харьцуулж шинжлэх нь илүү бодитой байдаг учир ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн нийт орлого, зарлага, тэнцлийг зураг 2-т нэгтгэн авч үзлээ.


Зураг 2. ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн нийт орлого, зарлага, тэнцэл (хувиар)



Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд тулгуурлан судлаач тооцоолов.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш 35 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт, уналтын хэд хэдэн мөчлөгийг туулсан бөгөөд сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг гурван удаагийн уналтын мөчлөгтэй тулгарсан юм. Энэ нь түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн огцом бууралт болон Ковид-19 цар тахалтай давхацсан байдаг. Харин эдийн засгийн огцом уналтыг сааруулахын тулд төсвийг их хэмжээгээр тэлэх бодлого явуулсан ч 2014-2016, 2020 онд эдийн засгийн идэвхжил хурдтай саарсан байна.

Зураг 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, тодотгол, гүйцэтгэлийн зөрүү




Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн талаарх Сангийн яамны мэдээлэл: www.iltod.gov.mn

Монгол Улсын төсвийн орлогыг тодорхойлдог ашигт малтмалын үнэ байнга хэлбэлзэж өөрчлөгдөж байсан тул түүний төсөөллийг үндэслэлтэй тооцоход хүндрэлтэй байдагтай төсөөллийн энэхүү алдааг зарим талаар холбон тайлбарлаж болно. Харин 2012 оноос энэ төрлийн алдаа харьцангуй багасаж байгаа нь төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн байдлаар тооцдог болсон, мөн татварын удирдлагад гарсан нааштай өөрчлөлтүүдтэй холбоотой. 2015, 2016, 2020 онд төсвийн орлогыг бууруулж, зарлагыг нэмэгдүүлэх тодотголыг хийж байсан бол 2018, 2019 онд тодотгол хийгээгүй, харин 2017, 2021, 2022 онд орлого, зарлагыг аль алийг нь нэмэгдүүлэх тодотгол хийжээ. Сүүлийн жилүүдэд буюу 2008-2017, 2020-2022 онд төсвийн жил бүр 1-3 удаагийн тодотгол хийж байсан нь төсвийн орлого, зарлагын тооцоолол үндэслэл багатайгаас гадна гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлтийн эрсдэлийг бүрэн тооцох чадавхгүй, төсвийн шийдвэр гаргалтад улс төрийн нөлөө ихтэй, төсвийн сахилга бат сул байгааг илтгэнэ.

Төсвийн орлогод хийсэн шинжилгээ: Татварын шинэчлэлийг 2006 онд хийсний зэрэгцээ эрдэс түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт, манай улсын уул уурхайн олборлох салбарын хөгжилд зохих үр дүнгээ өгч, төсвийн орлого 2009, 2015, 2016, 2020 оноос бусад онд өмнөх оноос нэмэгдсэн байна.

Зураг 4. Нэгдсэн төсвийн нийт орлогын бүтэц (хувиар)



Эх сурвалж: Сангийн яам. Монгол Улсын нэгдсэн төсвийн 1990-2024 оны үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн нийт орлогод татварын орлогын эзлэх хувийн жин хэт өндөр буюу 35 жилийн дунджаар 82.7 хувь байгаа нь Монгол Улсын төсвийн орлого тогтворгүй, эдийн засгийн мөчлөгүүдэд мэдрэмтгий байх эрсдэлийг дагуулж байна. Ялангуяа 2019-2024 онд төсвийн нийт орлогын 88.9-92.7 хувь, дунджаар 90.5 хувийг татварын орлогоор бүрдүүлж буй нь уг эрсдэлийг өндөр болгож байгаа юм.

Төсвийн татварын орлогын бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Төсвийн татварын орлогын бүтэц (хувиар)

Он	Орлогын албан татвар	Нийгмийн даатгалын шимтгэл	Өмчийн татвар	НӨАТ	Онцгой албан татвар	Тусгай зориулалтын орлого	Гадаад худалдааны татварын орлого	Бусад
1990	44.9	5.2	0	41.3	8.2	0	0	0.4
1991	50.3	0	0	11.1	30.9	0.2	5.7	1.8
1992	53.5	0	0	0.9	29.5	0.1	14.2	1.8
1993	57.1	0	0	14.3	13.2	0.8	13.2	1.3
1994	47.5	9.3	0	16.8	7.9	4.2	11.2	3.1
1995	46.0	14.9	0.1	15.4	8.1	3.1	9.1	3.3
1996	37.7	15.3	0	17.8	9.2	3.8	11.5	4.8
1997	38.2	13.0	0.1	23.3	12.4	3.0	5.4	4.8
1998	26.9	16.9	0.2	29.9	15.9	4.1	1.0	5.1
1999	21.6	16.5	0.2	33.1	14.8	3.8	5.0	5.1
2000	24.1	15.1	0.1	29.2	15.7	2.7	8.6	4.5
2001	19.7	16.4	0.5	31.8	16.3	2.7	8.2	4.5
2002	20.2	15.1	0.9	33	14.3	2.4	6.8	7.2
2003	23.2	15.5	1.1	29	13.9	2.3	7.8	7.3
2004	24.7	14.1	1	28	12.1	1.9	7.7	10.7
2005	25.8	13.8	0.9	26.2	11.4	1.6	8.2	12.1
2006	42.3	9.9	0.6	21.4	8.9	1.0	6.4	9.5
2007	43.2	10.7	0.5	17.6	8.9	0.9	6.8	11.4
2008	39.9	12.1	0.5	19.5	9.4	0.8	7.4	10.3
2009	32.2	15.9	0.7	20.2	10.3	1.0	7.2	12.5
2010	36.3	12.3	0.5	21.5	10.0	0.7	7.2	11.5
2011	22.7	12.9	0.5	30.4	8.0	0.7	9.2	15.6
2012	20.7	16.0	0.5	30.8	7.4	0.8	7.8	15.8
2013	21.9	17.2	0.9	28.3	8.9	0.7	7.5	14.6
2014	21.4	17.8	1.0	26.6	8.8	0.8	6.9	16.8

2015	22.9	19.9	1.7	20.5	11.6	0.2	6.3	17.0
2016	21.1	22.4	2.1	23.0	12.7	0.2	6.6	11.8
2017	25.5	20.9	2.1	25.6	8.2	0.2	8.1	9.3
2018	25.4	19.9	1.7	26.7	9.2	0.2	8.3	8.6
2019	26.0	20.7	1.6	25.3	8.8	0.2	8.1	9.3
2020	26.2	18.6	1.8	26.0	9.1	0.2	8.7	9.4
2021	29.4	20.2	1.8	25.1	7.3	0.1	8.3	7.7
2022	24.8	19.7	1.5	25.5	5.5	0.1	8.1	14.8
2023	22.6	20.0	1.0	25.2	5.1	0.1	8.7	17.2
2024	24.2	20.5	1.0	25.6	4.2	0.1	8.2	16.2
Дундаж	31.1	14.5	0.8	24.2	11.3	1.3	7.7	9.1


Эх сурвалж: ҮСХ, СЯ. Монгол Улсын 1990-2024 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Шилжилтийн эхний жилүүдэд төсвийн татварын орлогын ихэнх хэсгийг орлогын татвар бүрдүүлж байсан бол 1998 оноос хойш НӨАТ бүрдүүлэх болжээ. Үүний шалтгаан нь орлогын татварын шатлалд өөрчлөлт орж татвар багассан, үндэсний үйлдвэрлэлийн уналт шилжилтийн үед үргэлжилсээр байсан бөгөөд тэдгээрийн орлого ашиг мөн багассантай холбоотой. Нөгөө талаар татварын хэт өндөр хувь хэмжээнээс хамаарч аж ахуйн нэгжүүд зохиомлоор салж жижгэрэх, орлого ашгаа нуун дарагдуулах явдал элбэг байсан нь нөлөөлжээ. Үүний зэрэгцээ 1998 онд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулах болсноор төсвийн татварын орлогод эзлэх шууд бус татварын хувийн жин өсөхөд хүргэсэн байна. Иймээс 2006 онд татварын шинэчлэл хийж, татварын олон шатлалыг цөөрүүлэн, хувь хэмжээг бууруулжээ. Хэдийгээр 2006-2010 онд татварын орлогод орлогын татварын эзлэх хувийн жин эрс нэмэгдсэн нь татварын шинэчлэлийн үр дүн мэт харагдаж байгаа боловч “Зарим барааны үнийн гэнэтийн өсөлтийн албан татвар” хүчингүй болсонтой холбоотойгоор 2011 оноос эхлэн буурсан байна. Энэ нь татварын шинэчлэлийн бодит үр дүн биш, харин дээрх татварыг шинээр авах болсонтой холбоотой байсныг харуулна. Харин 2011 оноос төсвийн нийт орлогод орлогын албан татварын эзлэх хувь багасаж, НӨАТ-ын хувь хэмжээ өсөх хандлагатай болсон бол 2017 оноос орлогын албан татварын эзлэх хувь нэмэгдэж, НӨАТ-тай ойролцоо хувийг эзэлдэг болжээ.

Орлого, хөрөнгөд ногдуулан төсөвт шууд татвараар төвлөрүүлсэн орлогын нийт орлогод эзлэх хувь 1990-2002 оны дунджаар 48.3 хувь байсан бол 2003-2012 оны дунджаар 45.1 хувь, 2013-2024 оны дунджаар 45.6 хувь болсон байна. Харин хэрэглээнд ногдуулдаг шууд бус татварын орлогын хувийн жин харгалзан 48.1; 43.2; 41.6 хувь болж буурсан байна.

Төсвийн зарлагад хийсэн шинжилгээ: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1990-2012 онд жилд дунджаар 44.2 хувиар өсөж 4.8 их наяд төгрөгт хүрсэн бол 2013-2018 онд зарлагын өсөлтийн хурд харьцангуй саарсан байна. Уул уурхайн орлогын хурдацтай өсөлтийг дагаад төсвийн зарлага 2010 онд 31.7, 2011 онд 62.4 хувиар огцом өссөн бол 2012 онд 20.4, 2013 онд 2.4, 2014 онд 15.9, 2016 онд 33.0 хувь болж, зарлагын өсөлтийн хувь саарчээ. Харин 2015, 2017 онд өмнөх оноос 0.1-5.4 хувиар бага зарлага гаргасан бол 2018 онд 3.3 хувиар өсөж 9.3 их наяд төгрөгт хүрсэн байна. Төсвийн нийт зарлага 2019 оноос огцом тэлж, 2019-2024 оны дунджаар 19.7 хувийн өсөлттэй байгаа нь эдийн засаг дахь төрийн үүрэг, оролцоо эрс нэмэгдэж буйг харуулна.


Зураг 5. Нэгдсэн төсвийн зарлагын бүтэц (хувиар)



Эх сурвалж: ҮСХ, СЯ. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл. www.iltod.gov.mn

Төсвийн зарлагын бүтцийг 35 жилийн дунджаар авч үзэхэд нийт зардлын 74.8 хувийг урсгал зардал эзэлж байна. Төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 1998 оноос хойш бараг л 4 жил тутам өсөж, буурах мөчлөгтэй байгаа нь ажиглагдлаа. Урсгал зардлын эзлэх хувийн жин ийнхүү өндөр байгаа нь төсвийн бүтэц оновчтой бус, төсвийн хөрөнгийн идэвхгүй хэрэглээ нэмэгдэн татвар төлөгчдийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт хангагдахгүй байгааг харуулж байна. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 1993-2004 онд авсан зээлийн хэмжээнээс хамаараад цэвэр зээлийн эзлэх хувийн жин өссөн тул нийт зарлагад эзлэх урсгал зардлын хэмжээ хязгаарлагджээ. Шилжилтийн эхний жилүүдэд санхүүгийн хатуу бодлого явуулж, төвлөрсөн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байсантай холбоотойгоор хөрөнгийн зардал бага байсан боловч 1992-1998 оны хооронд хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин жил дараалан өссөн байна. Мөн 2008-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өсөж, нийт зарлагын 18.0-25.6 хувьд хүрсэн нь Монголын төр ирээдүй хойчоо харсан бодлого хэрэгжүүлсэн гэх дүгнэлтэд хүргэхээр байгаа ч төсвийн хөрөнгө оруулалт нь үр өгөөжтэй, үр ашигтай хийгдэж буй эсэх нь эргэлзээтэй.

Зураг 6. ДНБ-д болон төсвийн нийт зарлагад эзлэх хөрөнгийн зардлын хувь




Эх сурвалж: ҮСХ, СЯ. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд тулгуурлан тооцоолов.

Хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь 1990-2002 онд 4.8 хувь, 2003-2012 онд 6.6 хувь, 2013-2024 онд 7.6 хувь, нийт 35 жилийн дунджаар 6.3 хувь, харин төсвийн нийт зарлагад эзлэх хувь 1990-2002 онд 12.6 хувь, 2003-2012 онд 18.7 хувь, 2013-2024 онд 22.1 хувь, нийт 35 жилийн дунджаар 17.6 хувь болж өсөж байгаа нь улс орныхоо ирээдүйн хөгжилд төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт багагүй хэмжээтэй болсныг харуулна.

Төсвийн алдагдал, улсын өрийн шинжилгээ: Төсвийн нэгдсэн сахилга батыг хангах асуудал нь байгаа нөөцдөө багтааж зардал гаргах буюу дотоод орлого дээр гадаад зээлийн тогтвортой эх үүсвэрийг нэмсэнтэй тэнцүү хэмжээгээр зардал гаргахыг шаарддаг. Монгол Улсын ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувийг сүүлийн 35 жилээр гаргаж харууллаа.

Зураг 7. ДНБ-д төсвийн нийт алдагдлын эзлэх хувь, 1990-2024 он



Эх сурвалж: ҮСХ, СЯ. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл


Төсвийн нийт алдагдал 1991 онд ДНБ-ийн 11.6 хувь, 1998 онд 14.3 хувьтай тэнцэж байсан бол 2005-2007 онд 2.5-3.3 хувийн ашигтай гарч, 2008-2015 онд дунджаар 5.0 орчим хувийн алдагдалтай болжээ. 2010 онд төсөв бага зэргийн илүүдэлтэй гарсан хэдий ч 2016 онд сүүлийн 35 жилд байгаагүй их алдагдалтай гарч “төсвийн тэнцэл эрс доройтсон нь орлогын төлөвлөгөөг хэт өндөр тооцож, зарлага санхүүжилтийг эрс өсгөж төлөвлөсөн, УИХ, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нэг удаагийн арга хэмжээтэй шууд холбоотой” гэж Дэлхийн банкнаас дүгнэсэнтэй санал нэг байна.

Харин 2017 онд 6.4 хувийн алдагдалтай байсан бол 2018 онд УИХ-аас батлагдсан төсөвт тодотгол хийхгүй байх шийдвэрийг Засгийн газар, Сангийн яамнаас гаргаж ажилласны үр дүнд төсөв бага зэргийн ашигтай гарсан юм. Энэ нь төсвийн нэгдсэн сахилга батыг хангах, төсвийн зарлагыг үндэслэлгүй нэмэхгүй байхад чиглэсэн ач холбогдол бүхий арга хэмжээ болжээ. Ковид-19 цар тахал гарсны улмаас 2020 онд төсвийн өндөр алдагдалтай байсан бол 2021 оноос төсвийн алдагдал буурах хандлагатай байна.

Төсвийн тодотголыг хийхдээ орлогын хэмжээг багасгаж төлөвлөдөг боловч гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн төлөвлөгөөнөөс бага гардаг бөгөөд үүнийг эрдэс бүтээгдэхүүний зах зээл дээр урьдчилан тооцоолох боломжгүй савлагаа үүсдэг, мөн Засгийн газарт орлогын төсөөлөл гаргах чадавх сул байгаатай зарим талаар холбоотой байх талтай. Гэвч нэгдсэн төсвийн төслийг УИХ дээр хэлэлцэх үеэр нэмэлт зарлагыг санхүүжүүлэх зорилгоор эдийн засгийн хувьд үндэслэлгүй тооцоо судалгааг ашиглан орлогын хэмжээг өсгөх хандлага давамгайлдаг тул төсвийн орлогыг хэт өндөр төлөвлөдөг. Ийнхүү хэт өөдрөг тооцоо судалгаанд үндэслэж төсвийн орлогын төлөвлөгөөг гаргагдаас орлого ихээр тасрах нөхцөл бүрддэг. Төсвийн төлөвлөгөөг үнэмшилтэй болгох үүднээс орлогын төлөвлөгөөнд ашигладаг суурь нөхцөлийг бууруулж тооцон илүү үндэслэлтэй, бодитой тооцоо гаргадаг болох нь чухал.

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг сүүлийн 20 жилээр ДНБ-д эзлэх хувиар гаргаж зураг 8-д харууллаа.


Зураг 8. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: СЯ. Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт. <http://www.iltod.gov.mn/>

Нэгдсэн төсвийн нийт алдагдлыг санхүүжүүлэхдээ Засгийн газрын бондыг 2003, 2009, 2012, 2016, 2018, 2024 онд ихээхэн хэмжээгээр ашигласнаас гадна Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ 2016 оноос эхлэн эрс нэмэгдсэнийг харж болно. Түүнчлэн 2010-2012 онд уул уурхайн компаниудаас авах урьдчилгаа төлбөр алдагдлыг санхүүжүүлэх томоохон эх үүсвэр болсон байна. 2011 онд 461.5 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг авч Засгийн газраас иргэдэд олгох бэлэн мөнгөний шилжүүлэгт зориулжээ. Харин 2013 онд 812.5 тэрбум төгрөгийн бондыг шинээр гаргаж, шинээр 497.7 тэрбум төгрөгийн гадаад зээл авч Засгийн газрын урт хугацаат бондын үндсэн төлбөрт 421.8 тэрбум төгрөг, дотоод зээлийн үндсэн төлбөрт 192.1 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 84.7 тэрбум төгрөг, урьдчилгаа төлбөрийн буцаан олголт 95.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнд Монголбанкнаас үнэ тогтворжуулах хөтөлбөрт зориулсан 720 тэрбум төгрөгийн санхүүжилт, Чингис бондоор хэрэгжүүлсэн хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт ороогүй болно.

Зураг 9. Гадаад өрийн хүүгийн болон үндсэн төлбөр, 2005-2021 он, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Сангийн яамнаас гаргасан гадаад өрийн мэдээлэл

Сангийн яамнаас гаргаж буй төсвийн мэдээ, тайланд тусгагдсанаас харахад улсын өрийн тогтвортой байдлын шаардлага, сэрэмжлэх түвшнийг төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд хангаж байгаа мэт харагдаж байгаа боловч төсвийн хөрөнгө оруулалт, төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрийн санхүүжилтэд зориулж буй дээр дурдсан эх үүсвэрүүд тусгагдаагүй байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байгааг илтгэж байгаа юм.

Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2005 онд 1,700.0 тэрбум төгрөг, 2009 онд Засгийн газрын дотоод үнэт цаас гаргаж, Оюу толгой төслийн хүрээнд татварын урьдчилгаа төлбөр авч ашигласнаар 2009 онд Засгийн газрын өрийн үлдэгдэл 3,031.3 тэрбум төгрөг болж өссөн байна. Засгийн газрын өр 2012 оноос эхлэн гадаад үнэт цаас олон улсын зах зээлд арилжаалж эхэлсэн, дотоод үнэт цаасны гаргалт ихэссэн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж 2016 онд 22,280.1 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2017 оноос эхэлж дотоод үнэт цаас гаргалтыг зогсоож, баталгаа, концессын гэрээ байгуулаагүй зэргээс шалтгаалж өсөлт саарч 2021 онд Засгийн газрын өрийн үлдэгдэл 26,918.2 тэрбум төгрөг болжээ.

Өрийн тогтвортой байдлын тухайд аливаа улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэрлэсэн үнээр 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг "сайтар шинжлэх" шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг аж. Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2020 оны байдлаар 75.5 хувь байгаа бөгөөд 2021-2022 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд тус харьцаа 66.0 хувь болох тул "сайтар шинжлэх" шаардлагатай орны ангилалд орохоор байна.

Төсвийн Төсвийн тогтвортой байдлыг хангах, бодлогыг шинэчлэх чиглэл, арга зам

Төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангахын тулд төсвийн харилцаанд оролцдог байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгон зааглах, хязгаарлах чиглэлээр Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг нарийвчлах шаардлага тулгарч байна. Макро эдийн засгийн бодлогуудыг нягт уялдуулан төсвийн бодлогын арга хэрэгслийг хэрэглэх, төсвийн суурь шинэчлэлийг засгийн газрын бүтцийн болон хөрөнгө оруулалтын бодлогод нийцүүлж дорвитой өөрчлөлт хийхгүй бол төсөв тэлэх үзэгдэл цаашид ч зогсохгүй байх хандлагатай байна.

Төсөв боловсруулах үйл явц нь бодлого боловсруулах гэхээс илүү хянах үйл явц болж байгаа төдийгүй төсөв нь Засгийн газрын бодлого, стратегийн тусгал болж, хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын зорилтуудыг хангахад чиглэж чадахгүй байна. Энэ нь урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн уялдаа, бодлогын залгамж холбоог харгалзан төсвийн хуваарилалт хийх чадавх сул буюу хангалтгүй байгаатай холбоотой. Энэхүү чадавхыг бий болгохыг дэмждэг арга зүй болох хөтөлбөрт төсвийн аргаар зарлагын хуваарилалт, төсөвлөлтийг хийж байгаа боловч хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг төсвийн зарцуулалттай холбож тайлагнаж, дүгнэдэггүй, зарлагын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөний үнэлгээг төсвийн шийдвэрт харгалздаггүй байдал бүх шатанд оршиж байна.

Төсвийн шинэчлэл сүүлийн жилүүдэд эрх зүйн хүрээнд хийгдэж байгаа ч хэрэгжилтийн шатанд бодитой ахиц гарахгүй байгаа тул шинэчлэлийг үр дүнд хүргэхийн тулд суурь шинжтэй өөрчлөлтүүд хийх, тухайлбал, Засгийн газрын бүтэц, төсвийн харилцаан дахь парламентын оролцоо, төсвийн захирагчдын хариуцлага, ёс зүйн шаардлага зэрэгтэй уялдуулж өөрчлөлт хийх хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Иймээс **“Төсвийн шинэчлэлийн нэгдсэн стратеги”**-ийг салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан *макро түвшинд* - төсөв хоорондын харилцааны шинэчлэл, *мезо түвшинд* - төсвийн үйл явцын буюу төлөвлөлтийн шинэчлэл, *микро түвшинд* - төсвийн нэгж дэх шинэчлэл гэсэн гурван түвшнийг хамруулан цогц байдлаар боловсруулж, шат дараалалтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсад төсвийн шинэчлэлийг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд УИХ, Засгийн газрын зүгээс дараах чиглэлд анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй.

Төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах чиглэлээр:

- Төсвийн нэгдсэн сахилга батыг хангах, төсвийн хөрөнгийг стратегийн тэргүүлэх чиглэлд үр ашигтай хуваарилан төлөвлөх, батлагдсан төсвийг үр ашигтай, үр дүнтэй

зарцуулан үйлчилгээг үзүүлэх зорилтуудыг цогц байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд Засгийн газар, ялангуяа ЭЗХЯ, Сангийн яам илүүтэй анхаарч ажиллах

- Төсвийн зарлагыг тогтвортой хязгаарт барих замаар төсвийн орлогын төлөвлөгөө, төсөөллийг үндэслэлтэй, бодитой хийж, төсвийг жилийн дундуур тодотгохгүй байх
- УИХ-аас ТХМ-ийг батлах үйл явцад хариуцлагатай хандан жилийн төсвийн төслийг Засгийн газраас өргөн барих үед Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд, Төсвийн хүрээний мэдэгдэл (ТХМ)-ийн хязгаарлалтыг баримталсан эсэхэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн өмнө нь баталсан ТХМ-ийг жилийн дундуур өөрчлөхгүй байх зарчмыг мөрдөж ажиллах
- Хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангахад чиглэсэн шинэчлэлийг хэрэгжүүлэх, тухайлбал, Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсвийн зарлага, түүний дотор хөрөнгө оруулалтын төсөв, хөтөлбөрт төсвийн уялдааг нягт хангадаг байх
- Төсвийн мэдээллийн системийг иж бүрэн болгож, ялангуяа хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, үр дүнгийн мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлдэг тогтолцоог бий болгох

▪ УИХ-ын зүгээс төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох этгээдүүдийн гүйцэтгэх үүргийн хэрэгжилтийг нарийвчлан хянахад онцгой анхаарал хандуулж, парламентаар төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн батлахдаа ҮАГ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжид илүүтэй үндэслэдэг болох

Төсвийг үр дүнд чиглүүлэн гүйцэтгэлд суурилан төлөвлөх чиглэлээр:

- Үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарт туршсан үр дүнд тулгуурлан салбар, орон нутаг, байгууллагын төсвийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах замаар хөтөлбөрт төсөв, гүйцэтгэлд суурилсан төсөв, зүйл заалтын төсвийг хослуулан үр дүнд чиглэсэн дунд хугацааны төсвийн зарлагын төлөвлөлтийн аргыг мөн чанараар нь хэрэглэж хэвших. Үүний тулд хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон төсвийн уялдааг хангахад чиглэсэн төсөвлөлтийн арга зүйг боловсруулан чанд мөрдөж ажилладаг болох
- Зарлагын хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргахын тулд зардал-ашиг тусын, зардал-үр ашгийн, зардал-үр дүнгийн шинжилгээ хийх арга зүйг яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд хэрэглэхээр боловсруулан төсөв, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, төрийн сангийн ажилтнуудыг сургаж, чадавхжуулах
- Салбар, орон нутаг, байгууллагын түвшинд төсвийн хөрөнгийг зарцуулснаар хүрсэн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг жил, улирлаар тогтоож, ажлын гүйцэтгэл, үр дүнг төсөвтэй нь хамтатган тайлагнах, хянаж шинжлэх, үнэлэх, аудит хийх тогтолцоог цогц байдлаар бүрдүүлэх ажлыг УИХ, Засгийн газрын түвшинд хэрэгжүүлэх
- Төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах эрх зүйн зохицуулалт, арга хэлбэр, төсвийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох зохицуулалтыг илүү тодорхой болгож, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг эрс сайжруулах

Төсвийн зарлагыг үр ашигтай, үр дүнтэй зарцуулах чиглэлээр:

- Батлагдсан төсөвтөө багтаан төсвийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулахыг төсвийн захирагчдаас шаардан хүрсэн үр дүнгээс нь хамааруулан урамшуулдаг, хариуцлага тооцдог системийг бий болгох

- Зарлагын хөтөлбөр, түүний үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, хэрэгжилтийг тайлагнах загвар, аргачлалыг холбогдох төрийн байгууллагууд болох ҮАГ, ЗГХЭГ, ЗГХХГ, Сангийн яам, салбарын яамдын оролцоотойгоор боловсруулж, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудад суурилан төсвийн зарлагатай нь уялдуулж, батлан ягштал мөрдөж ажилладаг болох
- ҮАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг УИХ-ын хуралдаанд танилцуулж, хэлэлцэн Засгийн газрын үйл ажиллагаа, ТЕЗ-дын ажлын үр дүнг үнэлэх талаар шийдвэр гаргадаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох
- Улсын болон орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог иж бүрнээр нэвтрүүлж, батлагдсан төсвөөр хүрсэн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, төсвийг төлөвлөх, батлах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянаж шинжлэх, үнэлэх, аудит хийх үе шат бүрд харгалзан үздэг хариуцлагын тогтолцоотой болж, бодитой хэрэгжүүлэх
- Төсвийн зарлагын гүйцэтгэл, үр дүнд байнгын шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, судлаачдаар гэрээлэн гүйцэтгүүлж, төсвийн урсгал зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр нарийвчилсан судалгаа хийлгэж, судалгааны үр дүн, зөвлөмжид тулгуурлан цаашдын бодлого, зорилтыг тодорхойлдог байхыг санал болгож байна.

Дүгнэлт

Төсвийн шинэчлэл нь тасралтгүй үйл явц бөгөөд тухайн орны төрийн салбарын онцлог, гадаад орчны өөрчлөлт, хэрэгжүүлж буй төрийн захиргааны шинэчлэлийн бодлого, уялдаа холбоо, төрийн албаны соёл, төсвийн байгууллагуудын чадавх, иргэдийн хүлээлт, шаардлага зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан үр дүн нь харилцан адилгүй байдаг.

Монгол Улсад 2003 оноос хойш хэрэгжүүлсэн төсвийн шинэчлэлийн үр дүнг дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

- 1) Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн онцлог, гадаад болон дотоод орчны өөрчлөлтийг харгалзан төрийн захиргааны болон макро эдийн засгийн шинэчлэлтэй уялдуулан төсвийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж иржээ.
- 2) Монгол Улсад хэрэгжиж буй төсвийн шинэчлэл нь төсвийн хөрөнгийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулж төсөвлөх, төсвийн үр өгөөжийг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн харилцаанд оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэж буй дэлхий нийтийн шинэчлэлийн хандлагын дагуу хэрэгжиж байна.
- 3) Төсвийн шинэчлэлийн үзэл баримтлал, зарчмыг хуульчлан баталгаажуулснаар төсвийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зарцуулалтад тавих явцын хяналт сайжирсан, төсвийг хөтөлбөрөөр төлөвлөх болсон зэрэг нааштай үр дүн гарч байна. Энэ нь 2018, 2019 онд УИХ, Засгийн газрын зүгээс төсвийн жилийн дундуур төсвийн тодотгол хийхгүй байх, Засгийн газраас парламентад өргөн барьсан төсөвт үндэслэл багатай, улс төрийн шинжтэй өөрчлөлт оруулахгүй байх, төрийн хэмнэлтийн горимд шилжих, үр дүнд чиглэсэн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг зарим яаманд турших зэрэг бодлогыг хэрэгжүүлсний үр дүнгээр нотлогдож байгаа юм.

Монгол Улсад хэрэгжүүлж буй төсвийн шинэчлэлийн хүрээнд дээр дурдсан эерэг үр дүн илэрч байгаа ч төсвийн сахилга бат хангалтгүй, хариуцлагын тогтолцоо, хяналтын үр нөлөө сул, төсвийн зарлагын төлөвлөлтийг хөгжлийн бодлоготой уялдуулж, үндэслэлтэй төлөвлөж чадахгүй байгаа, батлагдсан төсвийг үр ашиг, үр дүнтэй зарцуулдаггүй байдал хадгалагдсан хэвээр байна. Иймээс төсвийн шинэчлэлийг төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах, төсвийг үр дүнд чиглүүлэн гүйцэтгэлд суурилан төлөвлөх, төсвийн зарлагыг үр ашигтай, үр дүнтэйгээр зарцуулах чиглэлээр хэрэгжүүлбэл зохих санал, зөвлөмжийг гаргав.

Хавсралт 4. Төсөв ба макро хувьсагчдын 2024 оны төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү

Үзүүлэлт	Төсөөлөл	Гүйцэтгэл	Зөрүү
Эдийн засгийн өсөлт, хувь	5.36	4.7 (2024M11)	-0.7
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөг	87,858.7	81,497 (56187.9 2024Q3)	-6,361.7
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	3,379.8	3,390.5	10.7
Төсвийн нийт орлого, тэрбум төгрөг	23,693.6	31,375.1 (29,589.3-ТО)	7,681.5
Уул уурхайн орлого, тэрбум төгрөг	6,412.2		
Төсвийн нийт зарлага, тэрбум төгрөг	26,116.1	30,365.5	4,249.4
Цэвэр зээл, тэрбум төгрөг	3536562.5	374.4	

Хавсралт 5. Уул уурхайн секторын 2024 оны төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү

Үзүүлэлт	Төсөөлөл		Гүйцэтгэл		Зөрүү	
	Тоо хэмжээ	Үнэ, \$/тн	Тоо хэмжээ	Үнэ, тн	Тоо хэмжээ	Үнэ, \$/тн
Зэсийн баяжмал, мян.тн	1,539	1,688	1,695.4	1,957.7	156.4	269.7
Нүүрс, мян.тн	58,496	104.4	83,755	103.85	25,259	0.55
Төмрийн хүдэр, мян.тн	6,865	105.18	7,510.52	79.6	645.5	25.6
Алт, тн	11.5	67,902,732.28	11.65	77,200,489.3	0.15	9,297,757

Хавсралт 4. Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал

№	Хамтран ажилласан байгууллага, албан тушаалтнууд	Албан бичгийн тоо
1	Монгол Улсад Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгаланд Мэдээлэл хүргүүлэх	1
2	Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай, Тайлан хүргүүлэх тухай, Макроэдийн засгийн үндсэн үзүүлэлт, тооцоолол хүргүүлэх тухай, Хуулийн төсөлд санал өгөх тухай, Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтын талаар, Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай, Төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх талаар, Мэдээлэл хүргүүлэх тухай	16
3	Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд Хуулийн төсөлд санал өгөх талаар, Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай, Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай	3
4	Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад Зардал санхүүжүүлэх тухай, Санал хүргүүлэх тухай, Хүсэлт гаргах тухай, Төлбөр шилжүүлэх тухай, Төлөвлөгөө хүргүүлэх тухай, Төсвийн сар улирлын хуваар авах тухай, Тайлан хүргүүлэх тухай, Зөвлөлийн 2025 оны төсвийн санал хүргүүлэх тухай, Зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх тухай, Нэмэгдэл цалин, орон тооны тухай	31
5	Сангийн яаманд хамтран ажиллах тухай, Уулзалт зохион байгуулах тухай, Макроэдийн засгийн үндсэн үзүүлэлт, тооцоолол хүргүүлэх тухай, Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	4
6	Эдийн засаг, хөгжлийн яаманд хамтран ажиллах тухай, Уулзалт зохион байгуулах тухай, Макроэдийн засгийн үндсэн үзүүлэлт, тооцоолол хүргүүлэх тухай, Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	4
7	Олон улсын валютын сангийн суурин төлөөлөгчийн газарт Хамтран ажиллах тухай	1
8	Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газарт Хамтран ажиллах тухай	1
9	Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газарт Хамтран ажиллах тухай	1
10	Монгол Улсын Их Сургуульд Тодорхойлолт хүргүүлэх тухай	1
11	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт Дэмжлэг хүсэх тухай	1
12	Монголбанкинд Заал ашиглах тухай, Нэвтрэх зөвшөөрөл хүсэх тухай	3
13	Европын холбооноос Монгол Улсад суугаа суурин төлөөлөгчийн газарт Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	1
14	Эдийн засгийн сэтгүүлчдийн клубт Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	1
15	Үндэсний аудитын газарт Мэдээлэл хүргүүлэх тухай	1
16	Монгол Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэл хүргүүлэх тухай	1
17	Гадаад харилцааны яаманд Хүсэлт гаргах тухай	1
18	Татварын мэргэшсэн зөвлөх ниймгэмлэгт Хамтран ажиллах тухай	1
19	Үндэсний дата төвд Домэйн нэр авах тухай	1
20	Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжалгалд санал хүргүүлэх тухай	1
	Нийт	75